



СОНГОГЧИЙН НОМ

Монгол Улсын Их Хурлын

СОНГУУЛЬ

2024

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СОНГОГЧИЙН НОМ

Боловсруулсан:

Ч.Сосорбарам /Түүхийн ухааны доктор/

Ч.Энхбат /Философийн ухааны доктор/

С.Оюунтуяа /Докторант/

Хянасан:

Д.Даваа-Очир /Хууль зүйн ухааны доктор/

УИН.МН
СУДАЛГААНЫ САН

Copyright© Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо. 2024 он

Энэхүү номыг зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, хэвлэх, олшруулах, нийгмийн сүлжээнд тараах, электрон мэдээллийн санд оруулах зэргээр ашиглахыг хориглоно.

Хэвлэлийн хуудас: 3.8 х.х

Хэвлэсэн хувь: 18 000 ширхэг

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГУУЛЬ, СОНГУУЛИЙН ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?

1. Сонгууль гэж юу вэ? Яагаад чухал вэ?
2. Сонгуулийн тогтолцоо
3. Сонгох эрх гэж юу вэ?
4. Сонгогдох эрх гэж юу вэ?

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛЬД ОРОЛЦОГЧИД

1. Сонгогч, сонгогчийн эрх үүрэг
2. Сонгуулийн байгууллага, түүний бүрэн эрх
3. Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч

ГУРАВДУГААР БҮЛЭГ. СОНГОГЧ СОНГУУЛЬД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

1. Сонгогчдын нэрийн жагсаалт гэж юу вэ?
2. Сонгуулийн сурталчилгаа, мөрийн хөтөлбөрийн тухай
3. Нэгдсэн самбар болон зурагт самбарын тухай
4. Сонгуульд хэрхэн мэдлэг, мэдээлэлтэй оролцох вэ?
5. Сонгогч саналаа хэрхэн өгөх вэ?
6. Гадаад улсад байгаа сонгогч саналаа хэрхэн өгөх вэ?
7. Сонгогч сонгуулийн үйл явцад хэрхэн хариуцлагатай оролцох вэ?

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМ

1. Сонгуулийн автоматжуулсан систем
2. Сонгогчийн санал тоолох, сонгуулийн дүн мэдээ гаргах баталгаажуулах үйл явц

Монгол Улсын Их Хурлын

СОНГУУЛЬ

2024

ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт “Монгол Улсын иргэн нь шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно.” хэмээн иргэний сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан байна.

Сонгогч танд хуулиар олгогдсон үндсэн эрхээ хэрэгжүүлэхэд тус нэмэр болох зорилгоор сонгуулийн тухай ойлголт, зорилго, түүнд оролцохын ач холбогдол болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулиар иргэн улс төрийн амьдралд оролцож төр барих эрхээ өөрийн сонгосон төлөөлөгчөөрөө дамжуулан эдлэх, сонгуульт албан тушаалтныг сонгох сонголтоо хэрхэн хийх, сонгуульд мэдлэг, мэдээлэлтэйгээр хэрхэн оролцох талаар товч ойлголтыг өгөхийг зорилоо. Түүнчлэн манай улсын сонгуулийн санал авах ажиллагаанд ашиглаж байгаа сонгогчийн бүртгэлийн болон санал авах, тоолох төхөөрөмжийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг “Сонгогчийн ном”-д орууллаа.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн онцлог нь мажоритар болон пропорционал тогтолцоог хослуулж явуулахаар болсон явдал юм. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог нь 5 бүсэд хамаарах бөгөөд орон нутагт 7, Улаанбаатарт 6, нийт 13 тойрог байхаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл, сонгогч Улсын Их Хурлын 126 гишүүний 78-г мажоритар буюу олонхыг төлөөлөх аргаар сонгоно. Харин 48 гишүүнийг пропорционалаар буюу хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгох хуулийн зохицуулалттай. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль нь нэр дэвшигчийн тоо, тойргийн нутаг дэвсгэрийн хэмжээ зэргээс хамааран санал авах үйл ажиллагаанд тодорхой өөрчлөлтүүд орж байна. Тиймээс сонгогчийн ном нь сонгогчдын боловсролыг дээшлүүлж, сонгуулийн үйл явцтай сайтар танилцах, сонгуулийн талаарх ойлголт өгөх, сонгуульд оролцох сонгогчийн оролцоог идэвхжүүлэхэд чиглэж байгаа юм.

Сонгогч Та сонгуулийн талаар мэдээлэлтэй болсноор тухайн сонгуульд идэвхтэй оролцож, сонголтоо хийхдээ хариуцлагатай хандана гэдэгт итгэл төгс байна.

МОНГОЛ УЛСЫН СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ
МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА, СУРГАЛТЫН ТӨВ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

1

СОНГУУЛЬ

СОНГУУЛИЙН ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?

.....

СОНГУУЛИЙН
СЭЛЭЛГ ААНЫ САН

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.

СОНГУУЛЬ, СОНГУУЛИЙН ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?

НЭГ. СОНГУУЛЬ ГЭЖ ЮУ ВЭ, ЯАГААД ЧУХАЛ ВЭ?

Үндсэн хууль бол “алганд багтсан” Монгол Улс юм.

**Б.Чимид, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар,
Ардын багш, Гавьяат хуульч, доктор профессор**

Сонгууль үүссэн хийгээд үргэлжилж ирсний уг шалтгаан нь ард түмэн улс орноо өөрсдөө удирдах амин хэрэгцээ мөн бөгөөд хамгийг эзэрхэгч хаант ёсыг халах, ганцаар дарангуйлагчийг хавчин зайлуулах тэмцлийн үр дүн¹ юм. Мөн ард түмэн засгийн эрхээ барих, түүнийгээ төлөөлөх байгууллагаараа уламжлан хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагаас урган гардаг ойлголт юм.

Монгол Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” гэж заасан байдаг. Тэгэхээр сонгуульд оролцож, саналаа өгнө гэдэг бол төрийн эрх барих эрх, эрх чөлөөгөө эдэлж буй хэрэг байх нь.

Сонгуулийн талаар олон янзын тодорхойлолт байдаг ч хамгийн түгээмэл ойлголт нь “Сонгуулийн эрх бүхий иргэдийг оролцуулан санал хураалт явуулах замаар улс төрийн шийдвэр гаргах үйл явц” юм. Улс төрийн шинжлэх ухаанд сонгуулийг “ард түмний бүрэн эрхт байдал, олонхын удирдлагын үзэл санааг хэрэгжүүлэгч” талаас нь, харин эрх зүйн шинжлэх ухаанд “Үндсэн хуулиар иргэдэд олгосон сонгох болон сонгогдох эрхийн баталгаа” талаас нь авч үздэг. Аль ч тохиолдолд сонгууль нь ардчиллын гол үнэт зүйл бөгөөд чөлөөтэй, шударга, тогтмол явагддаг гэдгээрээ ардчиллын хамгийн чухал шинж болдог. Монгол Улсын иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, төлөөллийн байгууллагыг өөрсдөө бүрдүүлж байгаа үндсэн арга нь сонгууль.

Ардчилсан улс орнуудад сонгууль дараах үндсэн шалгууруудыг хангасан байх ёстой² гэж үздэг.

- Сонгуулийн бэлтгэл ажил, санал хураалт, сонгуулийн үр дүн, сонгуулийн дараах бүхий л үйл явц улс төрийн эрх чөлөөт нөхцөлөөр хангагдсан байх;
- Сонгуульд саналаа өгч буй сонгогчид чөлөөтэй сонголт хийх боломжоор бүрэн хангагдсан байх;

¹ Сонгуульд суралцахуй. Б.Чимид, 21 дүгээр нүүр, УБ. 2008 он.

² Сонгогчдын боловсролын гарын авлага. 14-р нүүр, Сонгуулийн ерөнхий хороо, УБ. 2008 он.

- Сонгуульд өрсөлдөж буй нам, эвсэл, нэр дэвшигчид засгийн эрхийн төлөө шударгаар, чөлөөтэй, адил тэгш өрсөлдөх боломжоор хангагдсан байх;
- Сонгууль нь тодорхой хугацаанд тогтмол, ээлжит байх;
- Сонгуулийн үйл явцад жендэрийн тэгш байдлыг хангах

Эдгээр шалгуур нь сонгуульд өрсөлдөж буй оролцогчдын хувьд нэг ижил гараанаас гарч, сонгуулийн кампанит ажил, үйл ажиллагаанд зарцуулах хөрөнгө санхүү, хандивын хэмжээ, мэдээллийн хүртээмж, ухуулга сурталчилгаа хийх, мэдээллийн хэрэгсэл ашиглах боломжоор адил тэнцүү эрх эдэлж, үүрэг хүлээх ёстой гэсэн агуулгыг илэрхийлдэг байна.



Сонгуульд жендэрийн тэгш байдал буюу эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын бүрэн дүүрэн, эрх тэгш оролцоог хангах нь хүний эрхийн үндсэн асуудал төдийгүй тогтвортой хөгжил болон ардчиллын чухал шалгуур үзүүлэлт, урьдчилсан нөхцөл, үндэс суурь болдог. Түүнчлэн, сонгууль нь:


- Засгийн эрх барьж байгаа улс төрийн хүчний үйл ажиллагааг дүгнэх боломжийг сонгогчдод олгодог тул тогтмол хугацаанд зохион байгуулагдаж байх учиртай.
- Нийгмийн олон бүлгүүдийн, тэр дундаа эмэгтэйчүүд, залуучууд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэсний цөөнхийн төлөөллийг хангах, тэдний нийтлэг эрх, ашиг сонирхлыг илэрхийлсэн төрийн нэгдсэн бодлого боловсруулан хэрэгжүүлэх, төрийн бодлогын шинэчлэл хийх боломж олгодог.
- Тулгамдсан асуудлыг шийдэх бодлогын өрсөлдөөнийг дэмждэг.

Бидний өдөр тутмын амьдрал тогтмол хугацаанд зохион байгуулдаг сонгуулиар бий болдог төр засгийн байгууллагууд болон тэдний гаргадаг бодлого, шийдвэрээс ямагт хамааралтай байдаг. Тэгэхээр сонгуульд оролцоно гэдэг нь бид бүхэн өөрсдийн санаа бодол, хүсэл зоригийг төрийн бодлого, шийдвэрт тусгуулах гол алхам бөгөөд өөрсдөдөө ээлтэй ирээдүйг бий болгож, хүсч байгаа сайхан амьдралаа бүтээхийн тулд сонгогч идэвх, оролцоогоо


нэмэгдүүлэхээс эхэлнэ. Өөрөөр хэлбэл сонгуульд оролцож, саналаа өгөхгүй бол таны хүсэл зориг төрийн бодлого, шийдвэрт тусгалаа олж чадахгүй байх нь.

Тиймээс сонгуульд оролцож байгаа нам, нэр дэвшигчийн бодлого, мөрийн хөтөлбөрийг судалж, харьцуулж, сонгуулийн үйл явцад идэвхтэй оролцож, саналаа өгөх нь бид өөрсдийнхөө төлөө хийж байгаа хамгийн хариуцлагатай алхмын нэг болно.

Сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгох эрхтэй³. Сонгогч сонгуульд оролцож, саналаа өгөхдөө “Бид энэ удаагийн сонгуулиар ямар байгууллагыг сонгох гэж байна”, “Тухайн байгууллага нь ямар бүрэн эрх, чиг үүрэгтэй байгууллага вэ” гэдгийг ойлгож, мэдвэл илүү хариуцлагатай сонголт хийж чадна.



УИХ-ын сонгуульд сонгогчдын оролцоо (мянган хүн, хувь, онуудаар)



Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хүн	Сонгуульд санал өгсөн хүн
1085.2	1037.4
1147.3	1057.2
1247	1028
1329.8	1088.3
1542.6	1179.5
1840.8	1238.5
1932.3	1424.5
2003.9	1475.8

³ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 5.1 дэх хэсэг

1923

НУТГИЙН АРДЫН
ХУРЛУУД

1924

УЛСЫН ИХ
ХУРАЛ

1990

ЕРӨНХИЙЛӨГЧ

Монгол Улсад сонгох, сонгогдох эрх, сонгож байгуулах ёс, сонгох журмыг тогтоосон түүхтэй.

18-аас
дээш насны

НИЙТ
494.960
ХҮН

ОРОЛЦСОН

98,5%

Улс орон
даяар тусгаар
тогтнолын төлөө
бүх нийтийн
санал асуулгыг
явуулсан.



4251
САНАЛ ХУРААХ
ХЭСЭГТ



ЗӨВШӨӨРСӨН → **494.9**
ХҮН

ТАТГАЛЗСАН → **0** ХҮН

ТУСГААР ТОГТНОЛОО БАТЛАН ЗӨВШӨӨРӨВ.



1990 оны
сонгуульд



430 ТОЙРОГТ
2413 НЭР ДЭВШИГЧ
ӨРСӨЛДЖЭЭ

1990 оны
сонгуульд

Санал хураалтад нийт сонгогчдын
98.0 хувь оролцсон нь **чөлөөт**
ардчилсан сонгуулийн хувьд
ХАМГИЙН ӨНДӨР ИРЦ байв.

2020 оны
УИХ-ын сонгуульд

121
Бие даагч

606

151
Эмэгтэй
24.9%

НЭР ДЭВШИГЧ

ХОЁР. СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг мажоритар болон пропорциональ тогтолцоог хослуулж явуулахаар болсон. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойрог нь 5 бүсэд хамаарах бөгөөд орон нутагт 7, Улаанбаатарт 6, нийт 13 тойрог байхаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл, сонгогч Улсын Их Хурлын 126 гишүүний 78-г мажоритар буюу олонхыг төлөөлөх аргаар сонгоно. Олонхын тогтолцооны хувьд тухайн тойрогт ногдох мандатын тооноос шалтгаалж сонгогч сонголтоо хийнэ. Жишээ нь, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай аймгууд нь баруун бүсэд хамаарах 2-р тойрог гэж ойлгож болно. 2-р тойрог нь 10 мандаттай байх бөгөөд сонгогч энэ тойрогт санал өгөх бол дэмжиж буй 10 нэр дэвшигчид саналаа өгнө. Илүү эсвэл дутуу дугуйлбал Таны санал хүчингүй болно гэдгийг анхаараарай.

Харин 48 гишүүнийг пропорциональ буюу хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно. Энэ нь Монгол Улс нэг тойрогт хамаарах тул сонгогч зөвхөн нэг нам, эвслийг дугуйлна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, улс төрийн нам нь тойрогт зориулсан бодлого боловсруулж өрсөлдөх бус улсын хэмжээний бодлого боловсруулах үндсэн чиг үүрэгтэй нь холбоотой. Тиймдээ ч улс төрийн нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн гэж хуульчлагдсан байдаг.

Нам, эвсэл нь нэр дэвшүүлэхдээ нийт нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь аль нэг хүйсийнх байхаар Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөд тусгасан. Мөн нам, эвсэл жагсаалтаар нэр дэвшүүлэхдээ 1:1 харьцаагаар нэр дэвшигчдээ жагсаах бөгөөд нийт нэр дэвшигчийн хүйсийн харьцаа 50:50 байхаар хуульд заасан байна.



ГУРАВ.

СОНГОХ ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?

“Улс төрийн намууд нэр дэвшүүлнэ гэдэг нь сонгочихлоо, үүрэг хүлээлгэчихлээ, одоо “өрөө нэхэж, ашгаа хүртэнэ” гэсэн үг биш. Харин ард түмнээр сонголт хийлгэх гэж “өрсөлдүүлж” буй хэрэг юм.”

Б.Чимид, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын багш, Гавьяат хуульч, доктор профессор



Сонгох эрх болон сонгогдох эрхийг хамтад нь сонгуулийн эрх гэж нэрлэдэг. Энэ эрх нь иргэдийн төр засгийн үйл хэрэгт биечлэн оролцох үндэс суурь нь болж өгдөг.

Сонгох эрх гэдэг нь төрийн дээд болон орон нутгийн байгууллагад олон нийтийг төлөөлөх, тэдний эрх ашгийг хамгаалж ажиллах хүнийг сонгох үйл явцад иргэд шууд оролцож, саналаа чөлөөтэй илэрхийлэх боломжоор илэрхийлэгдэнэ.

Сонгуулийн эрхийг хүний суурь эрх болохынх нь хувьд манай улс нэгдэн орсон

олон улсын гэрээ болон үндэсний хууль тогтоомжоор хамгаалдаг.

Тухайлбал,

Хүний эрхийн түгээмэл тунхаглал⁴

Хүн бүр улс орноо удирдахад шууд буюу чөлөөтэй сонгосон төлөөлөгчдөөрөө уламжлан оролцох эрхтэй.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт⁵

Сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй.

Монгол Улсын Үндсэн хууль:

Шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй.

⁴ 1948 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагаас баталсан.

⁵ НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1966 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 2200А(XXI) тоот тогтоолоор баталсан.

Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, хөгжлийн бэрхшээл зэргээс үл хамааран ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй. Тухайлбал:

Хаана амьдарч, оршин сууж байгаа эсэхээс үл хамааран сонгох эрхтэй байх.

Гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа Монгол Улсын иргэд Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын сонгуульд оролцож саналаа өгөх эрхтэй. Харин аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуульд эдгээр иргэд оролцож, саналаа өгөх эрх зүйн үндэс, боломж одоогоор бүрдээгүй байна.

Хөгжлийн бэрхшээлээс үл хамааран сонгох эрхээ хэрэгжүүлэх боломжтой байх.

Хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой. Харааны бэрхшээлтэй сонгогч саналаа өгөхөд зориулсан саналын хуудсыг унших, саналаа тэмдэглэх тусгай зориулалтын брайль үсэг бүхий хавтас санал авах байранд байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлдэх, санал авах байранд тэргэнцэртэй сонгогч орох боломжтой байх зэрэг санал авах байрны стандарт, саналын хуудасны хүртээмжтэй байдлыг хангадаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль⁶-д Улс төрийн үйл ажиллагаанд оролцох тухай:

- Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- Бүх шатны сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгаа хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид хүртээмжтэй байна.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

Иргэний сонгох эрхийг дараах байдлаар баталгаажуулдаг:



БҮХ НИЙТИЙН БАЙХ ЭРХ:

Иргэд сонгуульд тэгш эрхтэй оролцохыг ойлгоно. Манай орны хувьд 18 насанд хүрсэн иргэн сонгуульд оролцож, саналаа өгөх эрхтэй бөгөөд яс үндэс, гарал, арьсны өнгө, хэл, хүйс, нийгмийн гарал байдал, өмч хөрөнгө, эрхэлж буй ажил, албан тушаал, шашин шүтлэг, боловсролын түвшин, хөгжлийн бэрхшээл зэргээс үл хамаардаг. Гэсэн хэдий ч тухайн сонгуулийн зарчмыг хэрэгжүүлэхэд тодорхой хязгаарлалт, хориглолтууд бий. Тухайлбал, хорих газар ял эдэлж байгаа этгээд, мөн сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийг удирдах чадваргүй, өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй болсон этгээдийг эрх зүйн бүрэн чадамжгүй хэмээн шүүхийн шийдвэрээр тогтоосон бол сонгуульд оролцох эрх эдэлдэггүй.

ШУУД СОНГОХ ЭРХ:

Сонгогч сонгуульд ямар нэгэн төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө гаргаж, оролцох эрх бөгөөд сонгуулийн хууль тогтоомжид зааснаар сонгогч саналаа өөрөө биечлэн гаргах журамтай. Харин эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл, боловсролын түвшнээс шалтгаалан биечлэн өгөх боломжгүй бол өөрийн итгэмжилсэн хүний тусалцаа авч саналаа өгөхийг хуулиар зөвшөөрдөг.

САНАЛАА ЧӨЛӨӨТЭЙ ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ:

Сонгогч ямар нэг дарамт шахалт, сүрдүүлэг, хууль бус нөлөөлөлгүйгээр хуульд заасан хэлбэрээр сонгуульд оролцох, эс оролцохоо шийдэх, сонгуулийн үр дүнгээс шалтгаалан аливаа төрлийн шийтгэл, дарамтаас айж эмээхгүйгээр саналаа өгөхийг ойлгоно.

САНАЛАА НУУЦААР ГАРГАХ ЭРХ:


- Сонгох эрхийн язгуур зарчим бөгөөд ямар ч байдлаар хязгаарлагдах ёсгүй. Сонгогч ямар нэг айдас дарамт шахалтгүйгээр саналаа нууцаар илэрхийлэх боломжоор хангах үүргийг төрийн байгууллага хүлээдэг.

Эдгээрээс гадна бас нэгэн чухал зарчим бол сонгуулийн тэгш эрхийн тухай ойлголт юм. Хэдийгээр манай улсын сонгуулийн хууль тогтоомжид сонгуулийн тэгш эрхийн зарчмыг тусгаагүй ч сонгогч бүр адил тооны санал өгөх, санал бүрийн хувийн жин адил байх, нөгөө талаас сонгогдсон хүмүүс адил тооны сонгогчийг төлөөлж байх, сонгуулийн үйл явцад оролцогч талууд адил тэгш боломжоор хангагдах тухай асуудлыг зайлшгүй анхаарах ёстой.



Монгол Улс эмэгтэйчүүдэд сонгох эрхийг 1924 онд олгосон бөгөөд эмэгтэйчүүдийн сонгуулийн эрхийг хүлээн зөвшөөрсөн анхны 15 улс орны нэг нь юм.

Санал өгсөн сонгогч /насны ангиллаар/



ДӨРӨВ.

СОНГОГДОХ ЭРХ ГЭЖ ЮУ ВЭ?

*Сонгогдсон албан тушаалтны тайланг хэлэлцэх,
тэднийг сонгох нь маш чухал ажил.*

Аристотель (М.Э.Ө. 384–322)
Эртний Грекийн философич



Сонгуульд улс төрийн нам өөрийн гишүүд, дэмжигчдийнхээ дундаас нэр дэвшүүлж оролцдог бол иргэн хүн ч гэсэн хуульд заасан болзол, шаардлагыг хангавал Ерөнхийлөгчийн сонгуулиас бусад сонгуульд бие даан нэрээ дэвшүүлж болдог. Эдгээр оролцогчдын дундаас сонгогч өөрийн дэмжиж буй нам, эвслээс нэр дэвшигч, аль эсвэл бие даан нэр дэвшигчдийн төлөө саналаа өгдөг.

Сонгогдох эрх нь төрийн зохих байгууллага, тодорхой албан тушаалд олон нийтийн итгэл найдварыг хүлээх үндсэн дээр сонгогдох, уг албан тушаалаар хүлээсэн үүргээ хуульд заасан хугацаанд гүйцэтгэн биелүүлэх боломжоор илэрдэг. Гэхдээ сонгогдох эрх нь иргэний хувьд сонгох эрхийн нэгэн адил зөвхөн насны хязгаарлалттай байх боловч тухайн байгууллага, албан тушаалд сонгогдож, эрх үүргийг нь биелүүлэхэд зохих дадлага, туршлага, боловсрол, мэдлэг чадвар, арга барил зайлшгүй хэрэгтэй байдаг. Сонгогдох эрхийг холбогдох сонгуулийн хууль тогтоомжид дараах байдлаар зохицуулсан байна.

Монгол Улсын Үндсэн хууль:

- Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль:

- **50 нас хүрсэн**, сүүлийн 5-аас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу Монгол Улсын уугуул иргэн Ерөнхийлөгчөөр **сонгогдох эрхтэй**.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль:

- **25 насанд хүрсэн**, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын гишүүнээр **сонгогдох эрхтэй**.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль:

- **18 нас хүрсэн**, ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр **сонгогдох эрхтэй**.

Сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд үндэслэл бүхий хязгаарлалт тавигддаг. Тухайлбал, бүхий л сонгуульд нэр дэвшигч нь хууль тогтоомжоор дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд,

- Банк, бусад хуулийн этгээд, иргэнд шүүхийн шийдвэрээр тогтоогдсон төлбөл зохих зээл, барьцаа, батлан даалтын өр төлбөргүй байх;
- Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх, аль нэг компанийн 51, түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшдэг бол тухайн компани нь албан татварын хугацаа хэтэрсэн өргүй байх;
- Гэмт хэрэг үйлдэж, шүүхийн хүчин төгөлдөр шийтгэх тогтоолоор ял эдэлж байгаа хүн нэр дэвшихийг хориглох;
- Авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон бол нэр дэвшихийг хориглох.

Эдгээр нийтлэг шаардлагаас гадна тухайн сонгууль бүрийн онцлогийг тусгасан тусгай шаардлагууд сонгогдох эрхэд тавигддаг. Тухайлбал,

- нэр дэвшин өрсөлдөх тохиолдолд эрхэлж буй ажил албан тушаалаасаа чөлөөлөгдөх;
- сэтгэцийн эмгэггүй байх;
- тухайн орон нутагтаа байнгын оршин суугч байх;
- зөвхөн Улсын Их Хуралд суудалтай нам нэр дэвшүүлэх эрхтэй байх гэх мэт.

Бие даан нэрээ дэвшүүлэх тохиолдолд нэр дэвших гэж буй тойргийнхоо тодорхой тооны сонгогчдын дэмжлэг авдаг. Тухайлбал, Улсын Их Хурлын гишүүнд бие даан нэрээ дэвшүүлэх бол сонгуулийн тойргийнхоо 801⁷, орон нутгийн сонгуульд нэр дэвших бол нийслэлийн Хурлын сонгуульд 501, аймаг, дүүргийн хувьд 201, суманд 51-ээс доошгүй сонгогчдын гарын үсгийг зуруулан⁸ дэмжлэг авдаг. Ийнхүү дэмжиж гарын үсэг зурж байгаа нь зөвхөн сонгуульд нэр дэвших боломжийг тухайн хүнд өгч байгаа хэрэг.

Сонгогдох эрхийн хувьд бас нэг чухал зүйл нь нэр дэвшигчдийн хүйсийн тэнцвэртэй байдал юм. Хүйсийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд зарим сонгуульд тодорхой квот тогтоож өгдөг. Улсын Их Хурлын сонгуульд нам, эвслээс нэр дэвшигчийн 30-аас доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна. Орон нутгийн Хурлын сонгуульд нам, эвслээс нэр дэвшигчийн 20-иос доошгүй хувь нь аль нэг хүйсийн нэр дэвшигч байна гэж заасан байдаг ч эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх оролцоо сул хэвээр байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонгогдох эрхийн асуудлыг холбогдох хууль тогтоомжоор баталгаажуулдаг.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль⁹-д Улс төрийн үйл ажиллагаанд оролцох тухай:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүн бүх шатны сонгуульд нэр дэвших, сонгогдох, төрийн аливаа албанд томилогдон ажиллахад нь улс төрийн нам, эвсэл, төрийн байгууллагууд дэмжих үүрэгтэй.
- Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг сонгогдох эрхээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар улс төрийн нам, эвслүүд бодлого, мөрийн хөтөлбөртөө тусгана.

⁷ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг


⁸ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг

⁹ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30 дугаар зүйл


НЭР ДЭВШИГЧДИЙН НАСАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА




УИХ-д НИЙТ 606 НЭР ДЭВШИГЧ ӨРСӨЛДСӨН БАЙНА.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬД 23 НЭР ДЭВШИГЧ ӨРСӨЛДСӨН БАЙНА.



УИХ-Д СОНГОГДСОН ЭМЭГТЭЙ ГИШҮҮДИЙН ТОО БАРИМТ



9 НЭР ДЭВШИГЧ ӨРСӨЛДСӨН
5 НЭР ДЭВШИГЧ ӨРСӨЛДСӨН
3 НЭР ДЭВШИГЧ ӨРСӨЛДСӨН
11 НЭР ДЭВШИГЧ ӨРСӨЛДСӨН
0 НЭР ДЭВШИГЧ ӨРСӨЛДСӨН
13 НЭР ДЭВШИГЧ ӨРСӨЛДСӨН

The background image shows a political rally or public event. In the foreground, a large crowd of people is seated in white plastic chairs, facing away from the camera. In the background, a stage is visible with several men in suits. One man is standing at a podium, and another is seated next to him. A large, semi-transparent number '2' is overlaid on the right side of the image. The text 'ХОЁРДУГААР БҮЛЭГ' is written in white, bold, uppercase letters across the middle of the image, partially overlapping the number '2'.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

СОНГУУЛЬД
ОРОЛЦОГЧИД

.....

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СОНГУУЛЬД ОРОЛЦОГЧИД

НЭГ. СОНГОГЧ, СОНГОГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

*“Муу удирдагчдыг саналаа өгөөгүй
сайн иргэд өөрсдөө сонгодог.”*

Жорж Жин Натан
Америкийн шүүмжлэгч,
сэтгүүлч, редактор

18 насанд хүрсэн, иргэний бүртгэлд бүртгүүлсэн, эрх зүйн бүрэн чадамжтай, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн Монгол Улсын иргэнийг сонгогч гэнэ. Монгол Улсын иргэд бид нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, төрийн эрх барих дээд байгууллага болох Улсын Их Хурал, төрийн тэргүүн болох Ерөнхийлөгч, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болох Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлж байгаа үндсэн арга нь сонгууль юм. Харин шууд буюу төлөөлөгчдийн байгууллага гэдэг нь чухамдаа төрийн эрх барих, сонгуулиар бий болдог байгууллагуудыг хэлж байна.

Төрийн хэрэгт оролцоно гэдэг нь:

- Ерөнхийлөгч болон Улсын Их Хурлын гишүүдийг сонгох сонгуульд саналаа өгч оролцох;
- Ард нийтийн санал асуулгад оролцох, төр засгийн бодлого, шийдвэрт саналаа өгөх;
- Хууль дүрэм, бодлого, шийдвэрийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх үед санал өгөх эрхийг багтаадаг.

Хэдийгээр сонгогч сонгуульд оролцож саналаа өгөх нь төрийн эрх барих төлөөллийн байгууллага, Ерөнхийлөгч, нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгож байгуулах эрхээ эдлэхийн зэрэгцээ улс орныхоо ирээдүйн өмнө хүлээж буй маш том хариуцлага юм. Тиймээс:

- Сонгогч сонгуульд оролцож саналаа өгөхдөө хэр хариуцлагатай хандахаас төрийн бодлогын олон чухал асуудал хэрхэн шийдвэрлэгдэх нь хамаарна.

- Сонгогч сонгуулийн сурталчилгааны үед хууль зөрчсөн, шударга бус байдалд хэрхэн хандахаас сонгуулийн ардчилсан, шударга байдал шалтгаална.
- Сонгогч сонгуулийн үйл явц хуулийн хүрээнд шударга явагдаж буй эсэхэд иргэний хувьд хяналт тавих үүрэгтэй.
- Сонгогч бусдад сонгуульд оролцохгүй байхыг уриалах эрхгүй бөгөөд энэ нь таны хувьд хууль зөрчсөн үйлдэл болно гэдгийг мартаж болохгүй¹⁰.

Сонгуулийн эцсийн үр дүн сонгогч таны сонгуульд хэрхэн оролцож саналаа өгөхөөс шалтгаална.

Ардчилсан нийгмийн мөн чанар нь ард түмэн төрийн эрх барих төлөөллийн байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаа өөрсдөө сонгож байгуулдагт оршдог.

Хэдийгээр та сонгуульд оролцож саналаа өгөх, эсвэл оролцохгүй байхаа бие даан шийдэх эрхтэй боловч сонгуульд оролцож саналаа өгөх нь таны иргэний ухамсар, улс төрийн оролцооны илрэл гэдгийг мартаж өгөхгүй.

Таны хувьд сонгуульд оролцож саналаа өгнө гэдэг бол улс орны хөгжлийн бодлогын асуудлаар өөрийн байр суурийг илэрхийлэх боломж, хариуцлага гэдгийг ухамсарлах хэрэгтэй.

СОНГОГЧИЙН ЭРХ, ҮҮРГИЙН ТАЛААР ТА ЮУ МЭДЭХ ЁСТОЙ ВЭ?



1. Өөрийгөө төлөөлөх төрийн түшээг сонгох эрхтэй, мөн сонгосон төлөөлөгчөө хангалттай ажиллаагүй гэж үзвэл дахин сонгохгүй байх ч эрхтэй.
2. Улс төрийн аль нэг нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжих, эсвэл дэмжихгүй байх, тэдний талаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, хэн нэгний дарамт шахалтгүйгээр саналаа чөлөөтэй өгөх эрхтэй.
3. Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн онцлог, мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх төлөвлөгөө, тэдний мэдлэг боловсрол, туршлага, нэрээ дэвшүүлж өрсөлдөх болсон шалтгааны талаар мэдээлэл авах эрхтэй.
4. Улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн сурталчилгаандаа хэдий хэмжээний хөрөнгө зарцуулж, энэ зардал мөнгөө эх үүсвэрийн талаар мэдэх эрхтэй.

¹⁰ "Залуу сонгогчийн хөтөч" гарын авлага. Сонгогчдын Боловсрол Төв. 23 дугаар нүүр, УБ. 2020 он.

5. Таны сонгосон төлөөлөгч хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхийг хянах, тэдэнд асуулга тавьж, хариу авах, биечлэн уулзах, захидлаар харилцах, утсаар ярих зэргээр санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

Сонгуульд саналаа өгснөөр төрийн эрх барих эрхээ дөрвөн жилд нэг удаа эдэлдэг ч үүнийг зөвхөн нэг өдрийн хэрэг мэтээр хандаж болохгүй нь. Харин энэ нь бүхэл бүтэн 4 жилийн турш, нэг сонгуулиас дараагийн сонгууль хүртэл үргэлжилдэг хариуцлагатай оролцоо юм. Тиймээс сэдвийнхээ төгсгөлд хариуцлагатай сонгогч байхын тулд зайлшгүй анхаарах “Санал өгөх 7 алхам”¹¹-ыг орууллаа.

Алхам 1	Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэх, бүртгэгдсэн бол алдаа мадаггүй бүртгэгдсэн эсэх, бүртгэгдээгүй бол хуульд заасан журмын дагуу Улсын бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, бүртгүүлэх
Алхам 2	Сонгуульд оролцож буй нам, эвслийн мөрийн хөтөлбөр, алсын хараа, үзэл баримтлал, нэр дэвшигчдийн мэдлэг боловсрол, чадвар, ажлын туршлагын талаар хангалттай мэдээлэл цуглуулах
Алхам 3	Цуглуулсан мэдээллээ судалж, нам, эвсэл, нэр дэвшигчдийг харьцуулан үнэлж, цэгнэх
Алхам 4	Та өөрийн болон улс орны ирээдүйг найдан даатгаж болох, итгэл даах улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийг шилж сонгох
Алхам 5	Сонгуулийн санал авах өдөр сонгуулийн санал авах байр руу очоод саналаа өгөөрэй. Ингээд дууслаа гээд санаа амарч болохгүй
Алхам 6	Сонгуулийн дараа ч сонгосон төрийн түшээдийнхээ үйл ажиллагааг нь сайтар ажиглаж, үнэлж байх
Алхам 7	Бүрэн эрхийн хугацаа өнгөрсний дараа тэдгээр улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн төлөө дахин санал өгөх эсэхээ шийдээрэй.

¹¹ “Залуу сонгогчийн хөтөч” гарын авлага. Сонгогчдын Боловсрол Төв. 24 дүгээр нүүр, УБ. 2020 он.



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ
ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ИРЦ, НАСНЫ БҮЛГЭЭР


73.6%



2,003,969

1,475,780

Улсын дүн




Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо

Санал өгсөн сонгогчдын тоо, хувь

Өгөгдлийн дүрслэлийг Тунгаахуй өгөгдлийн урланд бүтээв.

УИХ-ЫН СОНГУУЛЬД СОНГОГЧДЫН ОРОЛЦОО

(насны бүлгээр, мян хүн, хувь, 2016 он)



Сонгуулийн насны



Сонгууль өгсөн



Сонгогчдын оролцоо

Хүйсээр авч үзвэл:



45.5%



54.5%

УЛС ОРНУУДЫН СОНГОХ НАСНЫ ХАРЬЦУУЛАЛТ

Дэлхийн 109 улс 18 нас, Бразил, Куба, Иран зэрэг улсад 16 нас, Наури, Иордан зэрэг улсад 20 нас, Кувейт, Тонка, Марокко зэрэг улсад 21 наснаас сонгох эрхээ эдэлдэг байна.





ХОЁР.

СОНГУУЛИЙН БАЙГУУЛЛАГА

Сонгуулийг бүх нийтийг оролцуулсан, тэгш, чөлөөтэй, шударга явуулах нь ард түмний хүсэл зоригийг бүрэн дүүрэн, үнэн зөв илэрхийлэх үндэс болно. Сонгуулийг ийнхүү явуулахад сонгуулийн байгууллага хамгийн чухал үүрэг, оролцоотой. Сонгуулийн үйл явц нь сонгуулийг албан ёсоор зарлах, сонгуулийн тойрог, хэсэг байгуулах, сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийг бүртгэх, сонгогчдын саналыг авах, сонгуулийн дүнг гаргаж мэдээлэх зэрэг олон үе шаттай, нөр их ажил байдаг. Сонгуулийг эхнээс нь дуустал бэлтгэн явуулж, хуулийн биелэлтийг хянаж, сонгуулийг бэлтгэн явуулах ажлыг бүхэлд нь зохион байгуулах бүрэн эрхтэй байгууллага бол сонгуулийн төв байгууллага юм.

Сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдлыг Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар тогтооно.

Сонгуулийн төв байгууллага буюу Сонгуулийн ерөнхий хороо

Сонгуулийн ерөнхий хороо сонгуулийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, хэсгийн хорооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг.¹²

Сонгуулийн байгууллагын тогтолцоо нь:

Орон нутгийн байгууллага буюу гадаад орнуудад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комисс, аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороо, сонгогчдын санал авах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий хэсгийн хорооноос бүрдэнэ.

Сонгуулийн ерөнхий хороо нь тогтмол үйл ажиллагаа явуулдаг бол орон нутгийн байгууллага нь түр зуурын шинжтэй, тухайн орон нутагтаа зөвхөн сонгуулийн үеэр байгуулагдан ажиллана.

Орон нутгийн сонгуулийн байгууллагад төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдыг томилон ажиллуулдаг.

¹²

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, 14.1 дэх хэсэг

Сонгуулийн байгууллагын үндсэн чиг үүрэг нь:

- ✓ сонгууль зохион байгуулж явуулах
- ✓ сонгуульд оролцож буй нам, эвсэл болон нэр дэвшигчидтэй харилцах
- ✓ сонгогчдод хандсан үйл ажиллагааг багтаадаг.



1

Сонгууль зохион байгуулж явуулах чиг үүргийн хүрээнд сонгуулийн байгууллага нь сонгууль бэлтгэн явуулах ажлыг төлөвлөх, зохион байгуулах, сонгуулийн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, сонгуулийн орон нутгийн байгууллагуудыг зохион байгуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сонгуулийн үйл ажиллагааны цаг хугацааны хуваарийг баталж, дагаж мөрдөх, төсөв хөрөнгийг хуваарилах, захиран зарцуулах, сонгуулийн дүнг нэгтгэн гаргах, нийтэд мэдээлэх зэрэг өргөн хүрээний асуудлыг хариуцдаг.



2

Сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчтэй харилцах чиг үүргийн хүрээнд сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчдийн сонгуульд оролцох хүсэлтийг хүлээн авах, холбогдох баримт бичгийг нягтлан шалгах, бүртгэх, нэр дэвшигчийн үнэмлэх олгох, тэдгээрийн үйл ажиллагаанд хуулийн дагуу хяналт, тавих зэрэг олон талт үйл ажиллагаа багтдаг.



3

Сонгогчдод хандсан үйл ажиллагаа зохион байгуулах чиг үүргийн хувьд сонгуулийн байгууллага нь сонгогчдыг сонгуулийн хууль тогтоомж, сонгогч сонгуульд хэрхэн оролцох талаар мэдээллээр хангахын зэрэгцээ тэднийг сонгох эрхээ хэрэгжүүлэхэд нь арга зүйн туслалцаа үзүүлэх, зөвлөгөө өгөх ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулдаг. Тухайлбал, Сонгуулийн ерөнхий хороо сонгууль бүрээр сонгогчдод зөвлөгөө, мэдээлэл, лавлагаа өгөх ажлыг Сонгогчдын Боловсрол Төвтэй хамтран хэрэгжүүлдэг бөгөөд үүний нэг нь "Сонгогчийн лавлах" шуудутас юм. Сонгогчид энэ утсанд хандан сонгуулийн хууль тогтоомжийн талаар болон сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллийг утсаар болон цахимаар авах боломжтой байдаг. Энэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг оролцоо маш чухал байдаг.

Сонгогчид сонгуульд оролцож саналаа өгөх ажлыг зохион байгуулдаг, сонгогчдод хамгийн ойр ажилладаг сонгуулийн анхан шатны байгууллага нь сонгуулийн хэсгийн хороо юм. Хэсгийн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

- санал авах өдөр, санал авах цагийг сонгогчдод мэдээлэх;
- санал авах байр, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, сонгогчийн бүртгэлийн болон санал авах, тоолох, дүн гаргах, дамжуулах төхөөрөмж зэрэг санал авахад шаардлагатай бусад зүйлийг бэлтгэх;
- санал авах ажлыг зохион байгуулах;
- санал хураалтын дүнг танилцуулах.

Аль ч шатны сонгуулийн байгууллага хамтын удирдлагатай, эрх хэмжээнийхээ асуудлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон хуралдаанаар хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэдэг. Хороод нь хуралдаанаар хэлэлцсэн асуудлаар тогтоол гаргаж, тухайн хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зуран баталгаажуулж, нийтэд ил тод мэдээлдэг. Сонгуулийн хороодоос бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэр, хуулийн дагуу өгсөн үүргийг тухайн нутаг дэвсгэр дэх зохих байгууллага, албан тушаалтан, иргэн биелүүлэх үүрэгтэй.

Сонгуулийн байгууллагын ажилтнууд нь сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигчийн талаар байр сууриа илэрхийлэх, сурталчилгаа явуулах, энэ зорилгоор сонгогчоос сонгуулийн эрхээ эдлэхэд болон санал авах, тоолох, дүн дамжуулах ажиллагаанд саад учруулах, бусдыг төлөөлж санал өгөх, гарын үсэг хуурамчаар үйлдэх зэрэг хууль бус аливаа үйлдэл хийх, зохион байгуулах, бусад хэлбэрээр дэмжихийг хориглодог.





Монгол Улсын Бага Хурлын 1992 оны 18 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хороог 15 гишүүнтэйгээр анх байгуулжээ.



2006



Сонгуулийн төв байгууллагын тухай хууль батлагдаж, Сонгуулийн ерөнхий хороо хараат бус, бие даасан байгууллага болов.

Сонгуулийн ерөнхий хороо нь 9 гишүүнтэй, байнгын үйл ажиллагаатай төрийн байгууллага.

Сонгуулийн үеэр аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороод, хэсгийн хороод байгуулагдан тэдгээрт төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид ажилладаг.



1945.10.20

Энэ өдөр улс орон даяар зохион байгуулсан тусгаар тогтнолын төлөө бүх нийтийн санал гаргуулах ажилд нийт

3304

КОМИСС
БАЙГУУЛАН
АЖИЛЛАЖЭЭ

17720

ХҮН
ОРОЛЦЖЭЭ

2020 ОНЫ УИХ-ЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛИАР



ГУРАВ.

УЛС ТӨРИЙН НАМ, ЭВСЭЛ, НЭР ДЭВШИГЧ

*Сонгогчидтойгоо холбоогүй болсон улс төрчид
"Хэн нь хэн бэ" гэдэг ангиллаас
"Энэ хэн бэ?" гэдэг ангилал руу шилждэг.*

**Уильям Ллойд Скотт (1915–1997),
Америкийн сенатор**

"Нам нь иргэдийн улс төрийн хүсэл зоригийг илэрхийлдэг, улсын хэмжээний бодлого дэвшүүлэн сонгуульд оролцдог, хамтын шийдвэр гаргаж, сайн дураараа эвлэлдэн нэгдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн." гэж улс төрийн намын тухай хуулиар тодорхойлжээ.

Улс төрийн нам гэдэг нь нийгмийн бүлгүүдийн улс төрийн сонирхол, зорилго, эрмэлзлийг нэгтгэн илэрхийлдэг, тэдгээрийн хамгийн идэвхтэй хэсгээс бүрдэж, төрийн эрх мэдлийг олж авах, хэрэгжүүлэхэд тэднийг удирдан зохион байгуулдаг улс төрийн нэгдэл юм⁴

Монгол Улсын иргэн "Нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй".

Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлээс

Улс төрийн намын үүслийг сонгуультай холбож үздэг бөгөөд анх 1867 онд Английн Бермингем хотод үүссэн гэж үздэг байна.

Улс төрийн намын ялгагдах гол шинж нь тэд засгийн эрх авахын төлөө үзэл бодол, бодлого хөтөлбөрөөрөө өрсөлдөж, эрх мэдлийг олж авсан нөхцөлд төрийн бодлогыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх боломжтой болдог. Тэгэхээр улс төрийн намын гол зорилго нь төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэх явдал бөгөөд энэ боломжийг зөвхөн сонгуульд оролцож олж авдаг. Тиймээс сонгууль бол улс төрийн намын үйл ажиллагааны хамгийн гол хэсэг байх нь. Сонгуулийн хууль тогтоомжоор сонгуульд оролцох улс төрийн намуудад тодорхой шаардлага тавигддаг. Үүнд,

- Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд Монгол Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн нам дангаараа, эсхүл хамтран оролцох;
- Улсын Их Хурлын сонгуулийн хувьд сонгууль товлон зарлахаас өмнө

Улсын Дээд Шүүхэд бүртгүүлсэн нам сонгуульд оролцох;

- Орон нутгийн Хурлын сонгуулийн хувьд сонгууль товлон зарласан өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт өөрийн салбартай нам оролцох боломжтой байдаг.

Улс төрийн намууд өөрсдийн үзэл баримтлал, алсын харааг үндэслэн улс орны нөхцөл байдал, олон нийтийн санаа бодлыг судалсны үндсэн дээр улс төрийн үйл ажиллагааны ойрын зорилтуудаа тодорхойлж, сонгуулийн хууль тогтоомжид нийцүүлэн мөрийн хөтөлбөр боловсруулж сонгуульд оролцдог. Тухайлбал, Улсын Их Хурлын болон Орон нутгийн Хурлын сонгуулийн хуульд “сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч дөрвөн жилийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна” гэжээ.

Улс төрийн намууд бусад намтай эвсэх боломжийг судалж, өөрийн намын сонирхлыг бусад намын сонирхолтой нийцүүлж, улс төрийн эвсэл байгуулж ажилладаг. Сонгуульд ч гэсэн улс төрийн нам дангаараа буюу хэд хэдэн намтай эвсэл болон оролцож болдог.

Сонгуулийн үйл ажиллагааны нэгэн салшгүй хэсэг бол нэр дэвшүүлэх үйл ажиллагаа юм. Улс төрийн нам Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн болон Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох нэр дэвшүүлэх үйл ажиллагаа, зарчим нь хууль, журмаар нарийвчлан зохицуулагдсан байдаг бөгөөд цаг хугацаа, тавигдах шаардлага, журам нь сонгууль тус бүрд ялгаатай боловч дараах нийтлэг зохицуулалт бий. Жишээ нь:

- Улс төрийн нам, эвсэл сонгуульд оролцохоо илэрхийлж, сонгуулийн холбогдох байгууллагад албан ёсоор бүртгүүлж байж оролцох;
- Улс төрийн намууд эвсэл байгуулж оролцох үйл явцыг нарийвчлан зохицуулж, эвслийн гэрээ байгуулах, гэрээнд тусгасан байх зайлшгүй шаардлагыг тодорхойлох;
- Сонгуулийн эрх бүхий байгууллага улс төрийн намыг бүртгэсний дараа хуульд заасан хугацаа, шаардлага, журмын дагуу нэр дэвшүүлэх ажлыг зохион байгуулах;
- Нэр дэвшигчээр бүртгэх, бүртгэхээс татгалзах, мөн нөхөн нэр дэвшүүлэх үйл явц;
- Ерөнхийлөгчийн сонгуулиас бусад сонгуулийн хувьд бие даан нэр дэвшүүлэх болзол, шаардлага, журам.

Улс төрийн намууд сонгуульд оролцохдоо тухайн сонгогдох албан тушаалд бүрнээ нийцэх хүнийг сонгон нэр дэвшүүлдэг. Намаас нэр дэвшүүлэх асуудлыг намын удирдах байгууллагын хуралдаанаар хэлэлцэж нууц санал хураалтаар, эвслээс нэр дэвшүүлэх асуудлыг эвсэлд орох нам тус бүр өөрт ногдсон

мандатад тохируулан нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэдэг.



“Нэр дэвшигч” гэж холбогдох хууль, журмын дагуу тухайн сонгуульд нэр дэвшиж бүртгүүлсэн, нэр дэвшигчийн үнэмлэх авсан иргэнийг хэлдэг.

Нэр дэвшигчдэд ажил хэрэг, нас, улс төрийн намын болон иргэний харьяаллын зэрэг өндөр шаардлага хуулиар тавигддаг. Тухайн албан тушаалд сонгогдож, эрхээ эдэлж, үүргээ биелүүлэхэд зохих дадлага, туршлага, боловсрол мэдлэг, авьяас чадвар, арга барил зайлшгүй хэрэгтэй. Тухайлбал, зан суртахууны хувьд эх оронч, үнэнч шударга, хувиа хичээх бус нийт иргэн, улсын ашиг сонирхлын төлөө ажиллаж чадах Монгол Улсын иргэн байх шаардлага тавигддаг.

Сонгуульд нэр дэвшигчдийн хувьд сонгуульд тэгш оролцож, шударгаар өрсөлдөх боломжийг сонгуулийн хууль тогтоомжоор хангаж өгдөг. Үүнд,

- Нэр дэвшигч өөрт шаардлагатай байгаа мэдээлэл, лавлагааг гаргуулан авах;
- Гэмт хэрэг болон зөрчил үйлдэх явцад, эсхүл гэмт хэргийн болон зөрчлийн газарт нотлох баримттай баривчилснаас бусад тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэсэн сонгуулийн хорооны зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэх, баривчлах, саатуулах, албадан саатуулах, цагдан хорих, орон байр, албан тасалгаа, тээврийн хэрэгсэл болон биед нь үзлэг, нэгжлэг хийхийг хориглох;
- Нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглох;
- Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн хувьд нэр дэвшигчийн нэрийг нийтэд мэдээлсэн өдрөөс эхлэн төрийн хамгаалалтад авах зэрэг баталгаагаар хангана.

СОНИРХОЛТОЙ ТОО БАРИМТ

- Улс төрийн намын үүслийг сонгуультай холбож үздэг бөгөөд анх 1867 онд Английн Бермингем хотод үүссэн гэж үздэг байна.
- Өнөөдрийн байдлаар Улсын Дээд Шүүхэд бүртгэлтэй 37 улс төрийн нам байна¹³.
- 1990 онд анх удаа олон нам сонгуульд оролцож, Ардын Их Хурлын депутатын 430 суудлын төлөө 2413 хүн өрсөлдөж байсан бол 2020 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуульд 13 нам, 4 эвсэл, 121 бие даан нэр дэвшигч нийт 606 нэр дэвшигч оролцсон байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

**СОНГОГЧ СОНГУУЛЬД
ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?**

.....

ГУРАВДУГААР БҮЛЭГ.

СОНГОГЧ СОНГУУЛЬД ХЭРХЭН ОРОЛЦОХ ВЭ?

НЭГ. СОНГОГЧДЫН НЭРИЙН ЖАГСААЛТ ГЭЖ ЮУ ВЭ?

Сонгуульд оролцох сонгогчийн үндсэн эрх нь сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэнээр баталгааждаг. Тиймээс сонгогчдын оролцоог нэмэгдүүлэх, сонгууль бүх нийтийн байх зарчмыг хангахад хамгийн түрүүнд сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой зохицуулалт, үйл явцыг мэддэг байх хэрэгтэй.



Сонгогчдын нэрийн жагсаалт гэж:

Сонгуульд оролцох эрх бүхий Монгол Улсын нийт иргэдийн бүртгэлийг сонгогчдын нэрийн жагсаалт гэж нэрлэдэг.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлыг Улсын бүртгэлийн ерөнхий газар холбогдох хууль тогтоомж, нарийн дэг журмын дагуу зохион байгуулдаг.

Сонгогчдын нэрийн жагсаалт нь цаасан болон цахим хэлбэртэй бөгөөд сонгогчийн талаар дараах мэдээллийг агуулдаг.



- ✓ Сонгогчийн эцэг /эх/-ийн нэр
- ✓ Өөрийн нэр
- ✓ Нас
- ✓ Хүйс
- ✓ Регистрийн дугаар
- ✓ Оршин суугаа газрын хаяг.

Сонгуулийн хууль тогтоомжоор сонгогч нэрийн жагсаалт дахь өөрийн болон өөрийн байнга оршин суугаа хаягийн бүртгэлд бүртгэгдсэн нийт сонгогчдын мэдээлэлтэй танилцах эрхтэй бөгөөд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсвэл буруу бүртгэгдсэн бол өөрийнхөө болон гэр бүлийнхээ өмнөөс гомдлоо холбогдох байгууллагад санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана. Энэ хуулиар тогтоосон хугацаанаас хойш гомдол гаргах боломжгүй тул аль болох эрт шалгаж, сонгуульд оролцох эрхээ баталгаажуулах ёстой. Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах ажил нь цаг хугацаа шаарддаг шат дамжлага ихтэй тул сонгогчдод сонгууль эхлэхээс ойролцоогоор бараг 3 сарын өмнө цахим байдлаар танилцах, баталгаажуулах боломжийг олгодог ч энэ боломжоо анзаарахгүй явж байгаад хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээллээ засварлуулах, энэ талаар гомдол гаргах боломжгүй болж улмаар сонгуульд саналаа өгч оролцох боломжоо ч алддаг гэдгийг анхаараарай.

Сонгогч нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ цахимаар болон биечлэн шалгах боломжтой.

Цахимаар хэрхэн шалгах вэ?	Биечлэн яаж шалгах вэ?
Сонгогчдын нэрийн жагсаалт election.burtgel.gov.mn цахим хуудсанд байршуулсан. ✓ Тиймээс сонгогч та өөрийн бүртгэлтэй танилцаж, бүртгэлээ баталгаажуулна. Үүний зэрэгцээ өөрийн оршин суугаа хаяг дээр бүртгэлтэй нийт сонгуулийн насны иргэдийн бүртгэлийг ч хянах боломжтой. ✓ Хэрвээ сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа мэдээлэл зөрүүтэй бол “Зөрүүтэй бол мэдээлэх” гэсэн товчийг дарж, байнга оршин суугаа хаягийн дагуу бүртгэлийн нэгжтэй холбоо барьж залруулгаа хийлгэнэ.	Сонгогч өөрийн харьяалагдах сонгуулийн хэсгийн хороонд сонгогчдын нэрийн жагсаалт очсон үеэс биечлэн шалгах боломжтой. ✓ Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, өөрийн ажиллах байргүй бол сум, хорооны Засаг даргын Тамгын газрын байранд сонгогч өөрт нь холбогдох мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломж олгоно. ✓ Сонгогч өөрийн харьяа хэсгийн хороондоо очиж сонгогчдын нэрийн жагсаалтад өөрийн болон гэр бүлийн гишүүдийг бүртгэгдсэн эсэхийг шалгах боломжтой. ✓ Хэрвээ сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, эсвэл буруу бүртгэгдсэн бол гомдлоо санал авах өдрөөс 14-өөс доошгүй хоногийн өмнө иргэний бүртгэлийн байгууллагад гаргаж шийдвэрлүүлнэ.

Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой дараах шалгах хуудсыг ашиглах боломжтой.

Шалгах асуулт	Хариулт		Авах арга хэмжээ
	тийм	үгүй	
Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн эсэхээ шалгасан уу?			Хэрвээ үгүй гэж хариулсан бол нэн даруй election.burtgel.gov.mn хаягаар нэвтэрч шалгана.
Сонгогчдын нэрийн жагсаалтад таны хаяг, регистр, санал өгөх байр зөв бүртгэгдсэн эсэхийг шалгасан уу?			Хэрвээ зөв бүртгэгдсэн бол “баталгаажуулах” товчийг дарах, буруу бүртгэгдсэн бол нэн даруй иргэний бүртгэлийн байгууллагатай холбоо барьж залруулна.
Сонгогчдын нэрийн жагсаалтад гэр бүлийн бусад гишүүд зөв бүртгэгдсэн эсэхийг биечлэн шалгасан уу?			Хэрвээ бүртгэгдээгүй, эсвэл буруу бүртгэгдсэн бол өөрийн болон гэр бүлийнхээ гишүүний нэрийн өмнөөс гомдлоо улсын бүртгэлийн байгууллагад бичгээр гаргана.



Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, нягтлан шалгах, давхардлыг арилгах ажлыг автоматжуулсан системээр 2012 онд анх удаа Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага зохион байгуулсан. Үүнд **2412** ширхэг сонгогчийн бүртгэлийн төхөөрөмжийг ашигласан байна.



Сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хэлбэрээр үйлдэж, сонгогчийн бүртгэлийн үйл ажиллагааг автоматжуулснаар **“НЭГ СОНГОГЧ-НЭГ БҮРТГЭЛ”** зарчим хэрэгжиж байна.



2020 оны Улсын Их Хурлын сонгуульд 2.003.969 сонгогч нэрийн жагсаалтад бүртгэгдсэн байна.



ХОЁР.

СОНГУУЛИЙН СУРТАЛЧИЛГАА, МӨРИЙН ХӨТӨЛБӨР ГЭЖ ЮУ ВЭ?

*УИХ бол ард түмний мэдэлд байгаа засгийн
эрхийг хэрэгжүүлдэг төрийн эрхийг барих дээд байгууллага.*

**Б. Чимид, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар,
Ардын багш, Гавьяат хуульч, доктор профессор**

Сонгуулийн тухай хууль тогтоомжоор сонгуульд оролцох нам, эвсэл, бие даан нэр дэвшигч сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд хэрэгжих сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байдаг. Нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь зөвхөн сонгуульд зориулсан, ялахын төлөө биш харин улс орны болон тухайн орон нутгийн хүний хөгжил, олон нийтийн нийтлэг эрэлт хэрэгцээг тусгасан, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх хугацаа, арга зам, хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтад нь багтаасан, хууль тогтоомжид заасан тодорхой шаардлагыг хангасан, бодлогын баримт бичиг байдаг. Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээ нь улс орны урт болон дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан арга хэмжээ хэрэгжүүлэхээр бол шаардагдах зардлын дүн нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд энэ талаар төрийн аудитын дээд байгууллага хянаж, дүгнэлт гаргадаг.

Улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчид улс оронд болон тухайн тойрогт нь тулгамдаж буй асуудлын талаар судалгаа, дүн шинжилгээ хийж, үүнийхээ үр дүнд тэдгээрийг сайжруулах арга замыг мөрийн хөтөлбөртөө тусгадаг. Улсын Их Хурлын сонгуулийн тухайд сонгуулиар олонх суудал авсан нам, эвслийн мөрийн хөтөлбөр нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн үндэс болдог тул сонгогчид мөрийн хөтөлбөрийг нь судалж үзэж

байж сонголтоо хийдэг. Өөрөөр хэлбэл, ямар асуудлыг дэвшүүлэв, түүнийг хэрхэн сайжруулна гэж амлав, тэр нь үнэхээр хэрэгжих боломжтой, бодит байдалд нийцэж байна уу гэдгийг судлах хэрэгтэй. Иймд сонгуулийн мөрийн хөтөлбөр нь сонгуульд оролцож буй нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны үндэс болдог, нөгөө талаас сонгогчид сонголтоо хийхэд шийдвэрлэх нөлөө үзүүлдэг.

Сонгуульд саналаа өгөхөөс өмнө нам, эвсэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр нь дараах асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, хэр бодитой үндэслэлтэй, хэрэгжихүйц санал дэвшүүлж байгааг тунгаагаарай¹⁴.



БОЛОВСРОЛ

Цэцэрлэг, ерөнхий боловсролын болон мэргэжлийн, их дээд сургуулийн хүртээмж, боловсролын чанар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэгш хамруулалт, насан туршийн боловсрол олгох, оюутны тэтгэлэг, сургалтын хөтөлбөр гэх мэт



ЭРҮҮЛ МЭНД

Эмч, эмнэлгийн хүртээмж, үйлчилгээний чанар, эм, эмчилгээний чанар, хангамж, хөнгөлөлт, эрүүл мэндийн даатгалын бодлого, спортыг дэмжих, хөгжүүлэх гэх мэт



ЭДИЙН ЗАСАГ

Ажилгүйдэл, татвар, жижиг дунд бизнесийг дэмжих бодлого, хувийн хэвшлийг дэмжих бодлого, ажлын байрны баталгаа, хямралыг арилгах бодлого, олон улсын зээл, тусламж гэх мэт



НИЙГЭМ

Нийгмийн халамж, тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн янз бүрийн давхаргын хүмүүс болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нэн ядуу хүмүүсийг хамарсан бодлого, өндөр настан, гэр бүл, эх нялхас, хүүхдэд ээлтэй бодлого, халамж, үйлчилгээ гэх мэт

СОЁЛ

Соёл урлагийг хөгжүүлж, уламжлалт бичиг соёл, түүхээ сурталчлан таниулах, дэмжих талаар бодлого, үйл ажиллагаа



ДЭД БҮТЭЦ

Барилга, зам, харилцаа, холбоо, техникийн хөгжил, дэвшил, явган хүний зам, тоглоомын талбай, байр хоорондын тохижилт, аж үйлдвэр, уурхай, нөхөн сэргээлтийн асуудал гэх мэт



ЗАСГИЙН ГАЗАР

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, төрийн албан хаагчийг сонгон шалгаруулах, ажиллуулах, хариуцлагын тогтолцоо зэрэг хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа, төсвийн зарцуулалт, түүний ил тод байдал, авлигатай тэмцэх арга зам, төрийн байгууллагын үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай, хүнд сурталгүй хүргэх, шүүх, цагдаагийн байгууллагын хараат бус үйл ажиллагааны талаарх бодлого гэх мэт.

Сонгуульд оролцохоо илэрхийлж бүртгүүлсэн улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчид өөрийн мөрийн хөтөлбөр, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар үзэл бодлоо чөлөөтэй тайлбарлан таниулах, нэр дэвшигчдээ сурталчлах зорилгоор хурал цуглаан хийх, уулзалт зохион байгуулах, ухуулах байр ажиллуулдаг бөгөөд үүнийг бүхэлд нь сонгуулийн сурталчилгаа гэж нэрлэж болно.

Сонгуулийн сурталчилгаа гэж¹⁵:



Нам, эвсэл, нэр дэвшигч, тэдгээрийн сонгуулийн байгууллага, ухуулагч, шадар туслагч, дэмжигчдээс сонгогчдод зориулан өөрсдийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулж, нэр дэвшигчдийг дэмжин сурталчилж байгааг хэлнэ.

Сонгуулийн хууль тогтоомжоор сонгуулийн сурталчилгааны дараах арга, хэлбэрийг тодорхойлсон. Үүнд:

- 1** Сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх
- 2** Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд сонгуулийн сурталчилгааны зурагт самбар байрлуулах
- 3** Намын далбааг гудамж, талбайд байрлуулах, таних тэмдэг, уриа ашиглах
- 4** Сонгогчидтой уулзалт, хурал, цуглаан хийх
- 5** Ухуулах байр ажиллуулах
- 6** Радио, телевизийн сурталчилгааны нэвтрүүлэг ашиглах
- 7** Цахим орчин ашиглах
- 8** Өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх.

¹⁵

Сонгуульд суралцахуй. Б.Чимид, 141 дүгээр нүүр, УБ. 2008 он

Сонгогч дараах хууль бус сурталчилгааг ялгаж таних нь хууль бус сурталчилгаанд автахгүй байх боломжийг олгоно.

Ээлжит сонгуулийн жил эхэлснээс санал авах өдөр дуустал ХОРИГЛОНО.

- ✗ мөнгө, эд зүйл тараах, бараа, эд зүйл хөнгөлөлттэй үнээр худалдах, аливаа үйлчилгээ төлбөргүйгээр болон хөнгөлөлттэй үзүүлэх
- ✗ нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн, баяр, наадам, урлагийн тоглолт, хүлээн авалт, дайллага, цайллага, төлбөрт таавар, бооцоот, мөрийтэй тоглоом зохион байгуулах, ивээн тэтгэх
- ✗ сонгогчдыг гадаад, дотоодод аялал зохион байгуулан оролцуулах, амралт сувилалд амраах, сувилуулах
- ✗ ирээдүйд өөрийн болон бусдын хөрөнгөөр мөнгө, эд бараа өгөхөөр гэрээ байгуулах, хэлцэл хийх
- ✗ хишиг, хувь, хувьцаа өгөх, ажлын байранд зуучлах, ажилд оруулах зэрэг амлалт авах
- ✗ сонгуульд оролцохоос татгалзахыг болон сонгуулийн хууль тогтоомж зөрчихийг уриалах
- ✗ хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт, санал асуулга зохион байгуулах

Сонгуулийн сурталчилгааны явцад ХОРИГЛОНО.

- ✗ хуульд зааснаас өөр арга хэлбэрээр сурталчилгаа хийх зөвшөөрснөөс бусад хугацаанд сурталчилгаа хийх
- ✗ сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусагдаагүй аливаа зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх талаар амлалт авах, ийм агуулга бүхий аливаа үйлдлийг сонгуулийн сурталчилгаанд ашиглах
- ✗ төрийн эх үүсвэр бүхий тээврийн хэрэгсэл, бусад өмч хөрөнгийг аливаа хэлбэрээр сонгуулийн сурталчилгаанд ашиглах
- ✗ оройн 22:00 цагаас дараа өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд чанга яригч ашиглах
- ✗ олон нийтийг хамарсан аливаа шашны зан үйл ашиглах, түүнийг зохион байгуулах, оролцох, ивээн тэтгэх, шашны холбогдолтой эд зүйл тараах.

Сонгуулийн ухуулга сурталчилгааг улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчийн сонгууль эрхэлсэн байгууллага эрхлэн явуулах бөгөөд үүнд намын дарга, эсхүл түүний итгэмжлэл олгосон албан тушаалтан, нэр дэвшигч, түүний ерөнхий менежер, менежер, шадар туслагч, ухуулагчид хамаардаг. Сонгуулийн сурталчилгаа явуулах эдгээр эрх бүхий ажилтнууд сонгуулийн байгууллагад бүртгүүлж, үнэмлэх авдаг бөгөөд бусад этгээд сонгуулийн сурталчилгаа хийхийг хуулиар хориглодог.



Сонгуулийн сурталчилгааны эхлэх, үргэлжлэх, дуусах хугацааг хуулиар тусгайлан зохицуулдаг.

200 сонгогч тутамд нэг ухуулагч ажиллуулахыг хуулиар зөвшөөрдөг.



200 СОНГОГЧ ТУТАМД **НЭГ**
УХУУЛАГЧ АЖИЛУУЛАХЫГ ХУУЛИАР ЗӨВШӨӨРДӨГ



Нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрийн агуулгад нийцсэн уриатай байж болно.



Сонгуулийн сурталчилгааны ухуулах хуудас нь нэг хэвлэлийн хуудас хүртэл хэмжээтэй байна, нэг хэвлэлийн хуудас нь А4 бичгийн цаасны найман нүүртэй тэнцүү байна.



Сонгуулийн мөрийн хөтөлбөрийг тайлбарлан таниулах, сурталчилгааны материалыг тараах, уулзалт, хурал зохион байгуулах чиглэлээр ухуулах байр ажиллуулдаг бөгөөд сонгуулийн нэг хэсэгт 2-оос илүүгүй байна.

ГУРАВ.


НЭГДСЭН САМБАР БОЛОН ЗУРАГТ САМБАР

Энэ удаагийн сонгуулиар нэвтрүүлэх сонгуулийн сурталчилгааны шинэлэг хэлбэр нь тойрогт нэр дэвшигчдийн зурагт хуудсыг байрлуулах нэгдсэн самбар юм.

Нэгдсэн самбарыг тухайн сум, дүүргийн Засаг дарга бэлтгэж, байршуулах ажлыг нь зохион байгуулах юм. Нэгдсэн самбарт байрлах нэр дэвшигчийн зурагт хуудас нь нэг хэвлэлийн хуудасны дөрөвний нэг буюу А3 хэмжээтэй байх бөгөөд нэр дэвшигч өөрт ногдсон хэсэгт зургаа байрлуулах юм. Сонгогчдын тоонд үндэслэн суманд хоёр, аймгийн төвийн суманд тав, хороонд дөрөв хүртэлх тооны нэгдсэн самбарыг байрлуулах бөгөөд сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар нэгдсэн самбар байршуулах цэгийг тогтооно. Ингэснээр сонгогч нэг дороос нэр дэвшигчдийн бүх мэдээллийг авах боломжтой болох юм. Энэ бол сонгуулийн мажоритар тогтолцоогоор буюу 78 мандатын төлөө тойрогт өрсөлдөх нэр дэвшигчидтэй холбоотой сурталчилгааны зохицуулалт юм.

Үүнээс гадна пропорционал буюу улс төрийн нам, эвслийн жагсаалтаар нэр дэвшигчдийн мэдээллийг байрлуулах самбар бас байна. Тухайн нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллага нь найман хэвлэлийн хуудаснаас илүүгүй хэмжээтэй зурагт самбарыг суманд нэг, хороонд хоёр хүртэлх тоогоор байрлуулж, зөвхөн нийтийн эзэмшлийн газар буюу гудамж, талбайд сурталчилгааны хугацаанд түр хугацаагаар, үнэ төлбөргүй байрлуулах бөгөөд сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар байршлыг нь тогтоох юм. Зурагт самбарт тухайн нам, эвслийн нэрийг дурдсан байхаар хуульд тусгажээ.

Нэгдсэн самбар болон зурагт самбар байрлуулахдаа замын тэмдэг, тэмдэглэгээ, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгслийг халхлах, бусдын эд хөрөнгө, явган зорчигчдод аюул учруулж болзошгүй байдлаар байрлуулах, замын хөдөлгөөнд саад учруулахыг хориглоно.



Нэр дэвшигчийн сонгуулийн сурталчилгааны нэгдсэн самбар




Нам, эвслийн сонгуулийн сурталчилгааны зурагт самбар

ДӨРӨВ.

СОНГУУЛЬД ХЭРХЭН МЭДЛЭГ, МЭДЭЭЛЭЛТЭЙ ОРОЛЦОХ ВЭ?

Сонгогчдын сонголтоо хийх гол хүчин зүйл нь мэдээлэл бөгөөд мэдээлэлтэйгээр сонгуульд оролцох асуудал хамгийн чухал. Яагаад гэвэл сонгуулийн кампанит ажлын хугацаа ерөнхийдөө богино буюу ойролцоогоор хагас сар орчим үргэлжилдэг. Тиймээс сонгогч сонгуулийн хууль тогтоомж, сонгуулийн үйл явц, сонгуульд оролцож буй улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаар хангалттай мэдээлэл авч сонгуульд оролцох нь сонгуулийн эрхээ бодитой хэрэгжүүлэх, сонгуульд хариуцлагатай хандах боломж олгодог. Үүнд дараах төрлийн мэдлэг, мэдээлэл хамаарна.

- Сонгуульд оролцож буй улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч, хийж хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлого, мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийн намтар, мэдлэг, туршлага, итгэл даах байдал, улс төрийн намын сонгууль эрхэлсэн байгууллага зэрэгт хамаарах мэдээлэл;
- Сонгуулийг удирдан зохион байгуулах байгууллага, тэдний бүрэн эрх, чиг үүрэгт хамаарах мэдлэг, мэдээлэл;
- Сонгуулийн хууль тогтоомж, сонгогчоос сонгох эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой, сонгогчдын боловсролд хамаарах өргөн хүрээний мэдлэг, мэдээлэл зэрэг.



Сонгогчид эдгээр мэдээллийг маш олон эх үүсвэрээс авдаг ч аль болох албан ёсны эх сурвалжаас авах нь тухайн мэдээллийн үнэн бодитой, аль нэг талыг бариагүй хараат бус байх шаардлагыг хангадаг. Тэгвэл сонгуулийн үед дээр дурьдсан мэдлэг, мэдээллийг сонгогч хэрхэн олж авах боломжтой вэ?

■ **Сонгуулийн байгууллагаас мэдээлэл авах** - Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар “сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт судалгаа явуулах болон сонгуулийн үйл явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах үүрэг” Сонгуулийн ерөнхий хороонд хамаардаг. Тиймээс сонгогч Сонгуулийн ерөнхий хорооны албан ёсны www.m-election.mn цахим хуудаснаас сонгуулийн талаар болон сонгогчдын боловсролд чиглэсэн мэдээлэл авах боломжтой.

Сонгуулийн хууль тогтоомжоор хэсгийн хороо нь “санал авах байрын дугаар, нэр, хаяг, байршил, орчин тойрны зураглалыг 14 хоногийн турш нийтэд зарлан мэдээлэх” чиг үүрэгтэй ажилладаг. Түүнчлэн, сонгогчдын санал хураах цаг, байр, түүний байршил, санал өгөх журам, сонгогчдын нэрийн жагсаалтын талаар холбогдох мэдээллийг сонгуулийн хэсгийн хороондоо хандан авах боломжтой.

■ **Сонгогчоос сонгох эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлж ажилладаг төрийн бус байгууллагуудаас мэдээлэл авах**

Сонгуулийг зохион байгуулах ажилд улс төрийн нам, эвслээс хараат бус, төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилго, дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, сонгогчдоос сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд арга зүйн зөвлөгөө тусламж үзүүлдэг, сонгуулийн үйл явц хууль тогтоомжийн хүрээнд явагдаж буй эсэхэд хөндлөнгөөс хяналт тавьж, үнэлгээ өгч ажилладаг олон төрийн бус байгууллагууд бий. Тухайлбал, Сонгогчдын Боловсрол Төв 1800-2800 “Сонгогчийн лавлах” утсыг 2012 оноос хойш сонгууль бүрээр тогтмол ажиллуулж ирсэн бөгөөд сонгогчид дараах асуудлын хүрээнд тус лавлах утсанд хандан мэдээлэл авах боломжтой.



- Сонгогчдын бүртгэл, нэрийн жагсаалттай холбоотой мэдээлэл;
- Саналын хуудас, сонгогч саналаа хэрхэн тэмдэглэх тухай;
- Сонгуульд ашиглах тоног төхөөрөмжийн талаарх танилцуулга, түүнтэй хэрхэн харьцах талаарх мэдээлэл;
- Сонгогчийн шилжилт хөдөлгөөн, түүнийг хэрхэн хийлгэх;
- Сонгуулийн сурталчилгаанд хориглосон арга, хэлбэрүүд, хууль бус сурталчилгааны талаар цагдаагийн байгууллагад хэрхэн мэдээлэх;
- Сонгогчдод хуулиар хориглосон үйлдлүүд;

- Сонгуулийн тухай хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн талаарх мэдээлэл;
- Сонгуулийг нээлттэй, шударгаар зохион байгуулахад иргэд, сонгогчид хэрхэн оролцох тухай мэдээлэл;
- Сонгуулийн хэсгийн хороодын байршил, хаяг, холбоо барих утасны дугаар зэрэг мэдээлэл;
- Сонгогчийн зүгээс болон сонгуулийн байгууллагын зүгээс санал авах өдөр анхаарах цаг үеийн шинжтэй дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг болно.

Радио, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудаас мэдээлэл авах

- Сонгуулийн тухай хууль тогтоомжоор “Радио, телевиз сонгогчдын боловсролд зориулсан мэдээ, мэдээлэл, нэвтрүүлэг, хөтөлбөр бэлтгэж түгээх үүрэгтэй” тул эндээс мөн сонгогчид мэдээлэл авах боломжтой. Мөн сонгуулийн хууль тогтоомжоор сонгуульд оролцож буй улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигч радио, телевизийг ашиглан сурталчилгаа хийх, өдөр тутмын болон бусад сонин сэтгүүлд сонгуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх зэргээр сонгуулийн ухуулга хийдэг.

Олон нийтийн цахим сүлжээгээр дамжуулан мэдээлэл авах – Сүүлийн сонгуулиудад нам, эвсэл, нэр дэвшигчид олон нийтийн цахим сүлжээг сонгуулийн ухуулга сурталчилгаанд ашиглах нь түгээмэл болсон бөгөөд сонгуулийн хууль тогтоомжоор сонгуулийн ухуулга сурталчилгааны нэг арга хэлбэрт тооцох болсон. Сонгуулийн сурталчилгаанд нэр дэвшигчийн болон нам, эвслийн өөрийн тус бүр нэг цахим хуудас, цахим орчин дахь олон нийтийн сүлжээний цахим хуудас болон бусад цахим хуудсыг сонгуулийн эрх бүхий байгууллагад бүртгүүлсний дагуу ашигладаг. Сонгуулийн ухуулга сурталчилгааны үед нэр дэвшигчийн нэр төр, алдар хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэх, ийм агуулга бүхий хэвлэмэл материалыг нийтэд тараах, эсхүл мэдээллийн хэрэгсэл, цахим орчин дахь олон нийтийн сүлжээгээр тараахыг хориглодог.

Цахим сүлжээнд нийтлэгдэж байгаа мэдээллийн үнэн худал эсэхийг нягтлах нь төвөгтэй байдаг. Тиймээс сонгогч хуурамч, худал, ташаа мэдээллийг ялгаж таних нь чухал.



Худал мэдээлэл - Хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллага, улс оронд хохирол учруулах зорилгоор санаатайгаар бий болгосон худал мэдээлэл.



Буруу ташаа мэдээлэл - Хохирол учруулах санаа, зорилго, агуулгатай худал мэдээлэл.



Хуурамч мэдээлэл - Бодит байдалд тулгуурласан бөгөөд хувь хүн, байгууллага, улс оронд хохирол учруулах, байгууллага, иргэний алдар хүндийг гутаах, олон нийтийг төөрөгдүүлэх зорилгоор түгээдэг мэдээлэл.

Сонгогч сонгуультай холбоотой бүхий л мэдээллийг аль болох албан ёсны эх сурвалжаас нь авч, мэдээллийг үнэн зөв, бодитой эсэхийг нягталж, эргэцүүлэн тунгаахдаа дараах зөвлөмжийг ашиглаарай.

Албан ёсны хуудас мөн эсэхийг магадлах.

- Сонгуулийн сурталчилгаанд нэр дэвшигчид өөрийн болон нам, эвслийнхээ нэрээр олон нийтийн сүлжээний цахим хуудас ашиглах болсон бөгөөд энэ хуудсаа Харилцаа холбооны зохицуулах хороонд албан ёсоор бүртгүүлдэг. Тиймээс албан ёсны хаяг нь мөн эсэхийг нягталж байгаарай.

Зөв бичих дүрмийн болон найруулга зүйн алдаатай эсэх.

- Зөв бичих дүрмийн алдаа ихтэй, найруулга зүйн хувьд ойлгомж муутай бичигдсэн мэдээ, мэдээллийг нарийн сайн нягталж, шалгаж байгаарай. Ийм мэдээлэл хуурамч байх магадлал өндөр.

Мэдээллийн талаарх сэтгэгдлийг шалгах.

- Цахим хуудсанд тухайн мэдээ, мэдээллийн дор бичигдсэн сэтгэгдлийг уншиж үзээрэй. Гэхдээ сэтгэгдэл бүхэн үнэн байдаггүйг бас бодоорой.

Цахим хуудасны найдвартай эсэхийг нягтлах.

- Хэрэв тухайн мэдээг таны өмнө нь ерөөсөө сонсож байгаагүй хэвлэл мэдээллийн байгууллага боловсруулж, нийтэлсэн байвал сэрэмжтэй хандаарай.

Хэн бичсэнийг нь шалгах.

- Хэрэв та мэдээлэлтэй нийгмийн сүлжээнд танилцсан бол тухайн мэдээллийн анхдагч эх сурвалж буюу анх хэн боловсруулсан, ямар мэдээ, мэдээллийн сувгаар цацагдсаныг шалгаж, мэдэхийг зөвлөж байна.

Зөвхөн гарчигт бүү итгэ, нийтлэл, мэдээг бүхэлд нь уншиж байх.

- Та аливаа мэдээллийг бусдад түгээх, хуваалцахаасаа өмнө тухайн мэдээ, мэдээлэл үнэн зөв эсэхийг заавал уншиж, нягталж байгаарай.

Интернет дэх "URL" хаягийг шалгаж үзэх.

- Хэрэв цахим хуудасны домайн нэр сэжиг бүхий, хачин санагдвал URL хаягийг нь шалгах хэрэгтэй.



Хошигнол эсэхийг нь нягтлах.

- Сонгогчдыг итгүүлэхийн тулд ихэнх хуурамч мэдээ, мэдээллийг санаатайгаар бэлтгэдэг тул тухайн мэдээ, мэдээлэл хошигнол, тоглоом болохыг ялгаж, мэддэг байх нь чухал.



- Сонгуультай холбоотой телевизийн мэдээллийн агуулга нь Захиалгатай буюу төлбөртэй сурталчилгаа 62 хувь, Сонгогчдын боловсролд зориулсан мэдээлэл 16 хувь, Далд сурталчилгаа 11 хувь, Ажил тайлагнасан талаарх мэдээлэл 11 хувь байжээ.

/Эх сурвалж: Глоб Интернэшнл ТББ, 2020 оны сонгуулийн сурталчилгааны телевизийн мониторинг судалгааны тайлан/



- Сонгуулийн үед фейсбүүкд түгээсэн мэдээллийн төрөл нь 18% нь сэтгүүл зүйн бүтээл, 23% нь сонгуулийн албан ёсны сурталчилгаа, 59% нь бусдыг төөрөгдүүлсэн, бүрэн бус мэдээлэл байжээ.

/2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн үеийн энэхүү мониторинг судалгааг БНОУХ-ийн DREAM хөтөлбөрийн хүрээнд Хэвлэлийн хүрээлэн зохион байгуулсан байна/



1800-2800

- Сонгуулийн үед сонгогчийн лавлах утас ажилладаг тул сонгогч холбогдож хууль ёсны, үнэн зөв, алдаа мадаггүй мэдээлэл авах боломжтой бөгөөд одоогоор 35000 орчим сонгогчийн дуудлага хүлээн авсан байна.

ТАВ.

СОНГОГЧ САНАЛАА ХЭРХЭН ӨГӨХ ВЭ?

*Санал хураалтаар үйл явдлын явцыг тодорхойлдоггүй,
харин үйл явдлын явцыг тодорхойлох хүнийг сонгодог.*

Джордж Уилл (Америкийн улс төр судлаач)

Сонгогчдын хувьд хамгийн хариуцлагатай мөч бол сонгуулийн санал авах өдөр сонгуульд оролцож саналаа өгөх явдал юм. Саналаа өгөх үйл явц гаднаас нь харахад нарийн төвөгтэй мэт харагдавч бодит байдал дээр тийм биш. Сонгуульд оролцож саналаа хэрхэн өгөх, юу анхаарах талаар сонгуулийн байгууллагууд, сонгогчдын боловсролын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагууд сонгогчдод хандан мэдээлэл, лавлагаа хүргэж ажилладаг тул санал авах байранд очихоос өмнө эдгээр байгууллагад хандан мэдээлэл, туслалцаа авч болно.

Сонгуулийн санал авах өдөр бүх нийтээр амрах өдөр байдаг. Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг 6 дугаар сарын 28-ны өдрийн баасан гарагт байхаар тогтоосон. Хэрвээ сонгуулийн санал авах өдөр ажиллаж байгаа сонгогч байвал байгууллагынх нь захиргаа чөлөө олгож, саналаа өгөх боломжоор хангах үүрэг хүлээдэг.

Сонгуулийн санал авах өдөр саналаа өгөх боломжгүй зарим сонгогчдын саналыг зөөврийн битүүмжилсэн хайрцгаар авдаг тусгай журам бий. Тухайлбал, эрүүл мэндийн байдлын улмаас санал авах өдөр санал авах байранд биечлэн очиж саналаа өгөх боломжгүй сонгогч сонгуулийн хэсгийн хороонд хуульд заасан журмын дагуу хүсэлт гаргаж саналаа өгөх боломжтой.

Сонгогч санал авах байранд хэрхэн саналаа өгөх талаар сонгуулийн хууль тогтоомжид ерөнхийд нь дараах байдлаар журамладаг.

- ✓ Санал авах ажиллагаа 07.00-22.00 цагийн хооронд үргэлжлэх тул энэ цагт амжиж ирж саналаа өгнө.
- ✓ Сонгогч санал авах байранд иргэний үнэмлэхтэйгээ ирж, саналаа биечлэн өгнө.
- ✓ Санал өгөхөөр ирсэн сонгогчийн гарын хурууны хээг тухайн хэсгийн сонгогчдын нэрийн жагсаалтын цахим хувилбартай тулган үзэж, зөрчилгүй бол сонгогчийн бүртгэлийн хуудас олгоно.
- ✓ Хэсгийн хорооны гишүүн сонгогчийн бүртгэлийн хуудсыг авч сонгогчид саналын хуудас олгоно.
- ✓ Саналын хуудас авсан сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсэг зурна.

- ✓ Сонгогч санал бэлтгэх бүхээгт очиж, саналын хуудаст бичигдсэн зааврын дагуу тэмдэглэгээ хийж саналаа өгнө.
- ✓ Сонгогч саналаа тэмдэглэсний дараа саналын нууцлалыг хангах зориулалт бүхий хавтсанд саналын хуудсаа хийнэ.
- ✓ Саналын хуудсаа санал тоолох төхөөрөмж /саналын хайрцаг/-д хийхдээ хавтаснаас гаргах шаардлагагүй. Энэ нь таны саналын нууцлалыг хангаж байгаа хэрэг.
- ✓ Тухайн сонгогч саналаа өгснийг илэрхийлэх тэмдэглэгээг Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу хийнэ. Ингээд сонгогч санал авах байрыг орхиж гарна.

Сонгогчдод саналаа өгөхөд дараах зүйлсийг хориглодог.

- ✗ Тухайн санал авах байранд санал өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх;
Өөр хүний бичиг баримт, хуурамч баримт бичиг ашиглаж санал өгөх, саналаа өгөхийг оролдох;
- ✗ Тухайн хэсгийн хорооноос олгосноос өөр саналын хуудас ашиглах;
- ✗ Санал авах байранд гаднаас саналын хуудас авч орох, эсвэл авч гарах;
- ✗ Саналын хуудсанд тэмдэглэсэн саналаа болон бусад сонгогчийн саналыг баримтжуулан зураг авах, дүрс бичлэг хийх, шууд дамжуулах үйлдэл хийх;
- ✗ Саналын хуудсанд хийсэн тэмдэглэгээг бусдад харуулах, зориулалтын бус үзгээр санал тэмдэглэх;
- ✗ Аль нэг нэр дэвшигчийн төлөө санал өгөх, эсвэл өгөхгүй байхаар амлалт авах, мөнгө, эд зүйл шаардах, авах.

Санал авах байранд хуулиар хориглосон зарим зохицуулалт:

- ✗ Санал авах байранд нэр дэвшигч болон зөвшөөрөлгүй бусад этгээд саналаа өгөхөөс бусад тохиолдолд байхыг хориглоно.
- ✗ Сонгогч саналын хуудаст саналаа тэмдэглэх үед тухайн сонгогчийн дэргэд өөр хүн байхыг хориглоно. Гэхдээ эрүүл мэндийн байдал, хөгжлийн бэрхшээл болон боловсролын түвшнээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн хүнээс туслалцаа авч саналаа өгөх боломжтой.


Сонгогч зайлшгүй мэдэх бас нэг чухал зүйл бол саналын хуудас. Саналын хуудас нь сонгогчоос саналаа илэрхийлэх, сонгуулийн дүн гаргах үндсэн баримт бичиг болдог. Өөрөөр хэлбэл, саналын хуудас нь сонгогчид өгч саналыг тэмдэглүүлээд, саналын хайрцагт хийлгүүлээд, түүнийг нь тоолоод хэн ялсныг нь тооцдог, сонгуулийн дараа тодорхой хугацаагаар хадгаладаг чухал баримт бичиг юм.

Саналын хуудас нь агуулга, бичилт, хэлбэрийн хувьд сонгогчоос саналаа илэрхийлэхэд хялбар, ойлгомжтой байх бөгөөд саналаа хэрхэн тэмдэглэх тухай заавар агуулсан байдаг. Тиймээс саналын хуудсанд тэмдэглэл хийхийн өмнө энэ заавартай сайтар, нямбай танилцаж, ямар нэг алдаа мадаггүй саналаа өгөх боломжтой. Хэрвээ сонгогч алдаа гаргавал тухайн саналын хуудсаа хэсгийн хороонд буцааж өгөөд дахин нэг удаа саналын хуудас авч саналаа өгөх боломжийг хуулиар олгодог.

Түүнчлэн сонгогч нэг ч нэр дэвшигчийн төлөө саналаа өгөөгүй бол хэнийг ч дэмжээгүй санал гэж үзэн саналыг тоолохгүй боловч тухайн сонгогчийг санал өгсөн сонгогчдын тоонд оруулан тоолно. Гэхдээ энэ саналын хуудас нь хүчинтэй саналын хуудаст тооцогддог. Энэ нь сонгуулийн саналаа чөлөөтэй илэрхийлэх зарчимд хамаарах юм. Батлагдсан загвар, шаардлагыг хангаагүй саналын хуудас нь хүчингүй байх бөгөөд хүчингүй саналын хуудсаар санал авах, өгөхийг хориглодог юм шүү.



**Санал авах ажил дунджаар 15 цаг үргэлжилдэг.
Санал авах өдөр 11-15 цагийн хооронд санал
авах байрны ачаалал илүү нэмэгддэг**



**Ерөнхийлөгчийн 2017 оны сонгуульд
26086 иргэн зөөврийн хайрцгаар санал
өгсөн.**

1992-2012 оны сонгуулийн дүнгээс харахад нийт саналаа өгсөн сонгогчдын 3 орчим хувь нь саналаа буруу тэмдэглэсний улмаас санал нь тоологдоогүй байна.

**Улсын Их Хурлын 2020 оны сонгуульд
19.956 сонгогч зөөврийн хайрцгаар
саналаа өгсөн.**

**Сонгуулийн санал авах өдрийг бүх нийтээр амрах өдөр болгон
хуульчилдаг. Энэ бол сонгуулийн эрхээ эдэлж, саналаа өгөх
боломжоор хангаж буй хэрэг.**

ЗУРГАА. ГАДААД УЛСАД БАЙГАА СОНГОГЧ САНАЛАА ХЭРХЭН ӨГӨХ ВЭ?

Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн хүрээнд Улсын Их Хурлын 48 гишүүнийг пропорционал тогтолцоогоор буюу намын жагсаалтаар сонгохоор хуульчилсан. Үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар гадаад улсад байгаа сонгогчдын саналыг 2024 оны 06 дугаар сарын 20, 21, 22, 23-ны өдрүүдэд буюу 4 хоногийн хугацаанд авахаар тогтсон юм. Гадаад улсад байгаа иргэн гадаадад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө буюу 2024 оны 06 дугаар сарын 15-наас өмнө сонгуульд оролцохоо мэдэгдэж, бүртгүүлнэ. Сонгогч Та харьяалах Дипломат төлөөлөгчийн газарт хандахдаа заавал биечлэн очих шаардлагагүй бөгөөд утас, факс, и-мэйл гэх мэт харилцаа холбооны бүхий л хэлбэрийг ашиглан бүртгүүлэх боломжтой. Харин санал авах өдөр сонгогч Та өөрийн биеэр санал авах байранд ирж, иргэний үнэмлэх, эсхүл үндэсний гадаад паспортыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулгаж, баталгаажуулсны үндсэн дээр саналаа өгөх юм. Гадаад улсад байгаа сонгогчийн саналыг Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд заасны дагуу тухайн улсын орон нутгийн цагаар 07:00-22:00 цаг хүртэлх хугацаанд салбар комиссын тогтоосон санал авах байранд авна.



ДОЛОО. СОНГОГЧ СОНГУУЛИЙН ҮЙЛ ЯВЦАД ХЭРХЭН ХАРИУЦЛАГАТАЙ ОРОЛЦОХ ВЭ?

Ард түмэн гэдгийг Улсын Ерөнхийлөгч хэлдэг үг. Эсвэл улсын хэмжээнд дийлэнхэд нь судалгаа хийсэн шинжлэх ухааны байгууллага өөрийнхөө өмнөөс биш шинжлэх ухааны үүднээс хэлдэг үг.

**Б.Чимид, Монгол Улсын Хөдөлмөрийн баатар,
Ардын багш, Гавьяат хуульч, доктор профессор**

Сонгуулийн үеэр сонгогчийн эрх болон сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн хууль бус үйлдлийн талаар мэддэг байх нь сонгох эрхээ хэрэгжүүлэх баталгаа болдог. Яагаад гэвэл,

- Сонгууль шударга, хуулийн дагуу явагдах нь сонгогчдын итгэл найдварыг бэхжүүлж, тэдний оролцоог нэмэгдүүлдэг.
- Сонгогчдын санал авах, дүн гаргах үйл явцад гарч болзошгүй алдаа, зөрчлийг илрүүлнэ.
- Зөрчлийг ил тод болгохоос гадна залруулах боломжийг сонгуулийн байгууллагад санал болгож, зөрчигдсөн тохиолдолд хариуцлага тооцож, сэргээх боломжийг олгодог.

Сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд хариуцлага хүлээлгэх чиг үүрэгтэй олон төрийн байгууллага байдаг ч сонгогчид сонгуулийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж оролцох нь дээр дурьдсанчлан сонгуулийг шударга, хуулийн дагуу зохион байгуулахад томоохон хувь нэмэр болдог. Тухайлбал, сонгуулийн хууль тогтоомжид дараах зохицуулалт бий.

- ✓ Сонгогчид бэлэн мөнгө, эд зүйл тараасныг сонгогч баримттайгаар цагдаагийн байгууллагад мэдэгдэж болно;
- ✓ Сонгогчид хууль бусаар мөнгө, эд зүйл тараасан болох нь тогтоогдсон бол мэдээлэл гаргасан иргэн тараасан бэлэн мөнгө болон эд барааны үнийн дүнг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг гэм буруутай этгээдээс гаргуулахаар шаардах эрхтэй.
- ✓ Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хууль болон Төрийн албаны тухай

хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан байдаг.

- ✓ Эрүүгийн хуулийн тусгай ангид хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн дараах төрлүүдийг заасан байна.
 - *Иргэний сонгуулийн эрхээ эдлэх, сонгуулийн хорооны ажилд саад хийх*
 - *Сонгууль, ард нийтийн санал асуулгад илүү санал өгөх*
 - *Сонгууль, ард нийтийн санал асуулгад хууль бусаар нөлөөлөх, санал хураалтын дүнг буруу гаргах*
 - *Сонгуулийн үеэр илт худал мэдээлэл тараах*
 - *Сонгуулийг хууль бусаар явуулах хуйвалдаан зохион байгуулах.*

Харин Зөрчлийн тухай хуульд “Улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зөрчил” гэсэн бүлэгт “Сонгуулийн хуулийг зөрчих” гэсэн хэсэгт 36 төрлийн зөрчлийг, хүлээлгэх хариуцлагын хамт жагсаасан байна.

Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн гомдол, маргааны хувьд сонгогч зайлшгүй мэдэж байх ёстой дараах зүйлүүд бий. Үүнд,

- Ямар ч тохиолдолд сонгуулийн аливаа хэрэг маргааныг тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ.
- Сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан дээд шатны сонгуулийн хороонд гомдлоо гаргана. Ингэхдээ тухайн шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор өргөдөл, гомдол, нэхэмжлэлээ гаргана.
- Сонгуулийн санал хураалтын дүнг өргөн мэдүүлсэн Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт гомдол гаргах бол Үндсэн хуулийн цэцэд хандах бөгөөд бусад тохиолдолд захиргааны хэргийн шүүхэд гаргана.

Түүнчлэн, сонгогчид сонгуулийн ухуулга сурталчилгааны явцад хяналт тавьж, үнэлгээ өгөх нь сонгуулийн үйл явцад хариуцлагатай оролцох боломжийг хангаж өгдөг. Сонгуулийн кампанит ажлын сурталчилгааны талаарх бодит мэдээллийг сонгогч дараах асуултад хариулснаар мэдэж авах боломжтой.





- Улс төрийн нам тайван жагсаал, цуглаан болон бусад арга хэмжээг чөлөөтэй зохион байгуулах эрх эдэлж байна уу?
- Иргэд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж, жагсаал цуглаанд оролцож чадаж байна уу?
- Сонгогчид сонгуулийн санал авах өдөр сонголт хийхэд чухал ач холбогдолтой улс төрийн нам, эвслийн мөрийн хөтөлбөр, бодлогын талаарх мэдээллийг хангалттай авч чадаж байна уу?
- Сонгуулийн үйл явцад идэвхитэй оролцоход шаардагдах сонгуулийн үйл явцын талаар мэдлэг, мэдээлэл /хаана, хэрхэн бүртгүүлэх, санал өгөх, өргөдөл гомдол хэнд, хэзээ гаргах/ сонгогч нарт байна уу?
- Сонгогч санал авах өдөр, хугацаа болон санал авах байрны байршлын талаар мэдээллийг авч чадаж байна уу?
- Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тухай өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэж байна уу?

Сонгогчийн бас нэг чухал оролцоо нь сонгуулийн үйл явцад улс төрийн намууд болон иргэний сонирхлын бүлгүүдээс хийх ажиглалтад оролцох боломж юм. Сонгуулийн хууль тогтоомжоор сонгуулийн ажиглалтыг нам, эвсэл, нэр дэвшигчдээс томилогдсон ажилтнуудаас гадна иргэний нийгмийн байгууллагын буюу хөндлөнгийн ажиглагчид хийх боломжтой.

Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага нь сонгуулийн үйл ажиллагаанд ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх эрхтэй¹⁷.

Эдгээр төрийн бус байгууллагууд Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлж, нэг санал авах байранд 2 хүртэл ажиглагчийг томилж ажиллуулдаг.

Сүүлийн олон удаагийн сонгуульд залуучуудын төрийн бус байгууллагууд нэгдэж, залуу ажиглагчдыг томилон санал авах байруудад ажиллуулж байгаа олон сайн жишээ, туршлагууд бий.

¹⁷ УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 67.13 дахь хэсэг

Ажиглагчийн эрх¹⁸

Ажиглагч нь санал авах, тоолох, дүн гаргах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаа эсэхийг зөвхөн хөндлөнгөөс ажиглах бөгөөд дараах эрх эдэлнэ.

- саналын хуудасны битүүмжлэгдсэн байдал болон зарцуулалтын тайлантай танилцах;
- санал авах үйл ажиллагааг ажиглах;
- санал бэлтгэх бүхээг, зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, санал тоолох төхөөрөмж, саналын хайрцаг болон санал авах байр хууль тогтоомжийн дагуу бэлтгэгдсэн эсэхтэй танилцах;
- санал авах үйл явцад зөрчил гарвал хэсгийн хороонд мэдэгдэж залруулахыг хүсэх;
- сонгогчийн саналаа нууцаар гаргах эрх болон сонгуулийн хорооны хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр дуу болон дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан сонгуулийн үйл явцыг баримтжуулах;
- хэсгийн хорооны гишүүдээс мэдээлэл авах;
- ажиглалтын тайланг бодит тоо, баримтад тулгуурлан гаргах;
- санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудас авах;
- цахим хэлбэрээр хуулбарласан саналын хуудасны зурган мэдээллийг авах;
- сонгогчдын нэрийн жагсаалтад орж байгаа өөрчлөлттэй танилцах, уг жагсаалтыг сонгогчдын нэрийн жагсаалттай тулган үзэх.

Сонгуулийн санал авах байрны гадаа орчинд болж байгаа зарим үйл явдал санал авах үйл явцад сөргөөр нөлөөлөх нь бий. Үүнд сонгогчид хяналт тавьж оролцох боломжтой. Тухайлбал, санал авах байрны гадна сонгогчдын саналыг худалдан авах, сонгуулийн хууль бус сурталчилгаа явуулснаар сонгогчдын сонголтод нөлөөлөх зэрэг ноцтой зөрчил сонгуулийн санал авах өдөр гарч болзошгүй, үүнийг сонгогчид зогсоож чадна.

UIN.VN
СУДАЛГААНЫ САН

¹⁸

УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 68 дугаар зүйл

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

4

СОНГУУЛИЙН

АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМ

.....

UIN.MN
СУДАЛГААНЫ САН





ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ.

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМ

Монгол Улс сонгуулийн үйл ажиллагаандаа автоматжуулсан төхөөрөмж ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлж, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг 2011 онд баталсан. Манай улс 2012 оны сонгуулиас эхлэн сонгогчийн санал авах, тоолох болон сонгогчийн бүртгэлийн үйл ажиллагаанд сонгуулийн автоматжуулсан системийг бүрэн нэвтрүүлж, нийт 8 удаагийн сонгуулийг амжилттай зохион байгууллаа.


Сонгуулийн автоматжуулсан системийг ашигласнаар сонгуулийн үйл ажиллагааны үед түгээмэл гардаг байсан гомдол, зөрчлийг арилган сонгогчийн бүртгэл хийх, санал авах, тоолох, сонгуулийн дүн гаргах ажилд хүний үйл ажиллагаанаас үүсэж болох хууль бус үйлдлээс сэргийлж, тэр хэмжээгээр сонгуулийн үеэр гардаг элдэв маргаан, зөрчлүүд буурсан төдийгүй сонгуулийн үр дүнг богино хугацаанд нэгтгэн, нийтэд мэдээлэх боломж бүрдсэн билээ.

Сонгуулийн үйл ажиллагаанд автоматжуулсан техник хэрэгсэл ашиглах тухай шийдвэрийг Улсын Их Хурлаас гаргадаг бөгөөд уг шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төв хариуцан ажиллаж байна. Аймаг, дүүргийн сонгуулийн хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн баг, хэсгийн хороон дээр ажиллах мэдээллийн технологийн даамлуудыг зохион байгуулалт, арга зүй, технологийн нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг.

СОНГУУЛИЙН АВТОМАТЖУУЛСАН СИСТЕМИЙН ИЖ БҮРДЭЛ

Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуульд тодорхойлсноор “автоматжуулах хэрэгслийн иж бүрдэл” гэж сонгогчийн болон санал хураалтын мэдээллийг оруулах, түүнийг боловсруулах, нэгтгэх, хадгалах, хайх болон үр дүнг дамжуулах зориулалттай, харилцан уялдаатай техник хэрэгсэл, программ хангамжийн нэгдлийг хэлдэг.

Сонгуулийн автоматжуулсан систем нь санал тоолох төхөөрөмж /New Image Cast/-ийн иж бүрдэл болон бүртгэлийн техник хэрэгслээс бүрдэнэ.



Одоогийн бидний ашиглаж буй **“Dominion Voting Systems”** компанийн бүтээгдэхүүн **“Image Cast Precinct”** гэдэг төхөөрөмж бол сонгуулийн хэсгийн санал авах байранд суурин саналын хайрцагтай лацдан байрлуулж, сонгогчийн саналаа тэмдэглэсэн саналын хуудсыг унших, саналын хуудсан дээрх сонгогчийн тэмдэглэсэн санал тэмдэглэгээг тоолж, дүнг нэгтгэх болон нэгтгэсэн дүнг Сонгуулийн Ерөнхий Хорооны төв серверт өндөр хамгаалалт бүхий тусгай сувгаар дамжуулах үүрэгтэй, сканнер хэлбэрийн хагас автоматжуулсан төхөөрөмж.

Уг систем нь Монгол Улсын “Сонгуулийн автоматжуулсан систем”-ийн тухай хуульд заасан шаардлагуудыг бүрэн хангасан бөгөөд сонгуульд ашиглахын өмнө төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагууд, сонгуульд оролцож байгаа нам, эвслийн төлөөллийг байлцуулан шалган туршиж, мэдээллийн технологийн мэргэжлийн ажилтнуудаас бүрдсэн Ажлын хэсэг баталгаажуулж, санал тоолох төхөөрөмж тус бүрд гэрчилгээ олгодог.

Манай улсын сонгуулийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй сонгуулийн автоматжуулсан систем нь санал авах өдөр ажиллаж байх үедээ ямар нэгэн сүлжээнд холбогдолгүй ажилладаг бөгөөд олон баримт үлдээдэг гэдгээрээ давуу талтай.

Сонгогч саналаа тэмдэглэсэн саналын хуудсаа төхөөрөмжид аль ч талаар нь харуулан уншуулахад саналын хуудсыг сканердан зургийг нь авч төхөөрөмжийн санах ойд хадгалдаг. Мөн тэмдэглэсэн саналыг тоолж, санал хураалтын дүнг сонгуулийн санал авах өдөр 22 цаг болмогц хэсгийн хэмжээнд нэгтгэн ямар нэгэн сүлжээнд холбохоос өмнө дүнгийн тайланг хэвлэн ажиглагчдад газар дээр нь хангалттай хэмжээгээр хэвлэж өгдөг. Ийнхүү дүнгийн хуудсыг хэвлэж өгсний дараа тусгай модемын тусламжтай сүлжээнд холбогдож дүнгээ дамжуулна. Мөн хэсгийн хороонд ажиллаж байгаа ажиглагчдад тухайн хэсгийн санал авах байрны санал тоолох төхөөрөмжид уншигдсан бүх саналын хуудасны зурган файлыг CD дээр буулгаж өгдөг. Дээр дурдсан бүх мэдээлэл нэгтгэгдэж байж сонгуулийн албан ёсны дүн гардаг.

Монгол Улс сонгуулийн үйл ажиллагаандаа автоматжуулсан системийг маш богино хугацаанд, бүрэн хэмжээнд амжилттай нэвтрүүлэн ашиглаж эхэлсэн цагаас эхлэн гадаадын олон орны сонгуулийн байгууллагууд, олон улсын ажиглагчдын анхаарлыг татсаар ирсэн юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны ээлжит сонгуулийн үйл ажиллагааг анх удаа гадаадын ажиглагчдын өргөн бүрэлдэхүүнтэй баг ажиглан хангалттай сайн гэдэг үнэлгээ өгсөн юм. Түүнчлэн Сонгуулийн тогтолцооны олон улсын хүрээлэнгээс “Сонгогчдод ээлтэй сонгуулийн байгууллага” гэсэн шагналыг хүртээсэн.

САНАЛ ТООЛОХ ТӨХӨӨРӨМЖИЙН ИЖ БҮРДЭЛ

- ✓ Санал тоолох төхөөрөмж
- ✓ Санах ойн төхөөрөмж /CF карт болон SD карт/
- ✓ Карт уншигч
- ✓ Хамгаалалтын соронзон түлхүүр
- ✓ Нөөц тэжээл, залгуур
- ✓ Нөөц тэжээлийн цэнэглэгч
- ✓ Дүн дамжуулах модем
- ✓ Дүн дамжуулах модемын залгуур
- ✓ Дүн дамжуулах сүлжээний нууцлалын төхөөрөмж

Санал тоолох төхөөрөмж



Санал тоолох төхөөрөмж нь дагалдах хэрэгсэл болон сонгуулийн программ хангамжийн тусламжтайгаар саналын хуудсыг таньж унших, саналын хуудасны зурган мэдээллийг хадгалах, сонгогчийн саналыг тоолох, үр дүнгийн тайлан хэвлэх, дүнг нэгтгэн Сонгуулийн ерөнхий хорооны төв серверт дамжуулах үүрэгтэй.

Санах ойн карт болон уншигч /CF карт болон SD карт/




Санал тоолох төхөөрөмжид 2 ширхэг CF эсвэл SD картыг тусгай зориулалтын үүрэнд лацдан хүргүүлнэ. Төхөөрөмжид уншигдсан саналын хуудасны зурган файлууд тус картуудад хадгалагдах бөгөөд санал хураалт дуусаж дүн дамжуулсны дараа ажиглагчдад саналын хуудасны зурган файлыг хуулбарлаж өгнө.

Соронзон түлхүүр



Санал тоолох төхөөрөмжийг ажиллуулахад соронзон түлхүүрийг ашиглах бөгөөд уг түлхүүр нь санал тоолох төхөөрөмжийг асаах, унтраах, тайлан хэвлэх, удирдлагын цэсэд нэвтрэх /цэвэрлэх/ Санал хураалтыг нээх, хаахад хэрэглэх бөгөөд тус түлхүүр нь зөвхөн тухайн төхөөрөмжид зориулагдсан байдаг.

Нөөц тэжээл, залгуур, түүний цэнэглэгч



Санал авах байрны цахилгааны ажиллагаа тасарсан үед санал тоолох төхөөрөмжийн хэвийн ажиллах ажиллагааг хангана. Мөн тухайн нөөц тэжээлийг шаардлагатай тохиолдолд цэнэглэх цэнэглэгч

Дүн дамжуулах модем



Санал хураалт явагдаж дууссаны дараа тухайн төхөөрөмжид уншигдсан нийт санал хураалтын дүнг Сонгуулийн ерөнхий хорооны төв серверт дамжуулах үүрэгтэй төхөөрөмж юм.

Дүн дамжуулах сүлжээний нууцлалын төхөөрөмж



Сонгуулийн төв серверт тухайн төхөөрөмжийн дүнг дамжуулахад тусгай нууцлалын сүлжээ ашиглан интернетэд холбогдох боломжгүйгээр дүнг нэн даруй илгээхэд хэрэглэгддэг төхөөрөмж юм.

“Image Cast Precinct” хэмээн нэрлэдэг манай улсад ашиглаж байгаа

санал тоолох төхөөрөмж нь зөвхөн саналын хуудсыг уншиж хадгалахаас гадна өөр олон төрлийн онцлог, давуу талуудтай.



- ✓ *Offline горимд буюу ажиллаж байх үедээ гадны ямар нэг сүлжээнд холбогдохгүйгээр ажилладаг тул дүнд нөлөөлөх боломжгүй.*
- ✓ *Саналын хуудсыг аль ч талаар нь уншина.*
- ✓ *Хоосон саналын хуудас болон илүү, дутуу тэмдэглэгээг танина.*
- ✓ *Давхар хуудас уншуулсан тохиолдлыг мэдэрнэ.*

СОНГОГЧИЙН БҮРТГЭЛИЙН СИСТЕМ

Сонгуулийн автоматжуулсан системийн нэг бүрдэл хэсэг нь сонгогчийг бүртгэх ажиллагаа. Сонгогчдыг биеийн давтагдашгүй өгөгдөл буюу хурууны хээний мэдээлэл, иргэний цахим үнэмлэхийн мэдээлэлд нь тулгуурлан сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэнэ. Сонгогч сонгогчдын нэрийн жагсаалтад онгогчдын нэрийн жагсаалтад зөвхөн НЭГ удаа бүртгэгдэх ёстой.

Бүртгэлийг улсын хэмжээнд нэгдсэн журмаар гаргах бөгөөд иргэний бүртгэлийн нэгдсэн санд тулгуурлан хийгддэг бөгөөд энэ ажлыг бүхэлд нь Улсын бүртгэлийн ерөнхий газар хариуцан зохион байгуулдаг.

Сонгогчийн бүртгэл хийх үед тухайн сонгогчийг мөн эсэхийг хэсгийн хороонд ажиллаж байгаа ажиглагчдад нотлон харуулах зорилгоор дэлгэц байршуулдаг.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгогчдод танилцуулах, сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой иргэдээс гаргасан гомдлын дагуу мэдээллийг нь тулгаж нягтлах, өөрчлөлт оруулах, санал авах өдөр сонгогчийн бүртгэл хийх, хэсгийн хэмжээний ирцийн мэдээллийг төв удирдлагын систем рүү илгээх үндсэн үүрэгтэй иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтнууд ажилладаг. Эдгээр ажилтнууд нь төрийн албан хаагчид байх бөгөөд улсын бүртгэлийн байгууллагаас зохион байгуулсан сургалтад хамрагддаг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СОНГОГЧИЙН САНАЛ АВАХ, ТООЛОХ АЖИЛЛАГАА



Монгол Улсад явагдаж буй сонгуулиудын санал хураалт Улсын Их Хурлаас тогтоосон санал авах өдөр явагддаг бөгөөд Улаанбаатарын цагаар өглөөний 07:00 цагт орон даяар нэгэн зэрэг эхэлж, 22:00 цагт дуусдаг.

Сонгогч нь санал авах байранд иргэний үнэмлэх болон түүнийг орлох баримт бичигтэй очиж саналаа өгөх ба сонгогчийн бүртгэл хийлгэсэний дараа саналын хуудсыг авч бүхээгт очин саналаа нууцаар тэмдэглэнэ. Саналын хуудсанд бичигдсэн нэр дэвшигчдийн нэрс дундаас өөрийн дэмжиж байгаа, тухайн тойрогт ногдсон мандатын тоотой тэнцүү тооны нэр дэвшигчийн эцэг эхийн нэр, өөрийн нэрийн өмнөх зууван дугуйг зориулалтын үзгээр будаж тэмдэглэн саналаа өгнө. Зориулалтын үзэг гэдэг нь спиртийн агууламж өндөртэй, тэмдэглэгээ хийхэд хурдан хугацаанд хатдаг, энгийн эсгий бал. Богино хугацаанд хатдаг учраас санал тоолох төхөөрөмж, саналын хуудасны тэмдэглэгээг бохирдуулахгүй байх ач холбогдолтой юм.

Сонгогч нь саналаа тэмдэглэсний дараа саналын хуудсыг хэсгийн хорооноос олгосон саналын хуудасны хавтаст хийж санал тоолох төхөөрөмж рүү очно. Төхөөрөмжийн саналын хуудас унших зориулалтын хэсэгт саналын хуудсаа уншуулахдаа хавтаснаас нь гаргах шаардлагагүйгээр шууд уншуулж болно. Энэ тохиолдолд Таны саналын нууцлал бүрэн хадгалагдах болно.

Ташаа мэдээ: Танд иргэний бүртгэлээс хэвлэж өгсөн бүртгэлийн хуудаснаас саналаа хэнд өгснийг мэдэж болно.

Залруулга: Сонгогч та саналаа хэний төлөө өгснийг танаас өөр хэн ч мэдэх боломжгүй.

Ташаа мэдээ: Санал тоолох төхөөрөмж сонгогчийн саналыг өөрчлөн тоолж, таны будсаныг арилгаж, өөрөөр буддаг.

Залруулга: Сонгуулийн автоматжуулсан систем хэрэглэж эхэлснээс буюу 2012 оноос өнөөг хүртэлх бүх сонгуулийн санал хураалт дууссаны дараа хяналтын тооллого хийж ирсэн ба зөрсөн тохиолдол нэг ч гараагүй. Одоогоор сонгогчийн тэмдэглэсэн саналыг арилгаж, өөрөөр буддаг шидтэн, технологи гараагүй байна.

ХОЁР. СОНГУУЛИЙН ДҮН МЭДЭЭ ГАРГАХ, БАТАЛГААЖУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн үйл явцыг нийтэд ил тод, нээлттэй явуулж ирсэн бөгөөд сонгуулийн дүн мэдээ гаргах үйл явцыг санал тоолох төхөөрөмжийн программыг боловсруулан, төхөөрөмжийг шалган турших, сонгуулийн хороодод хүргүүлэх, сонгуульд ашиглах, хэсгийн хороодоос дүн дамжуулах, ажиглагчдад дүн танилцуулах зэрэг бүхий л үйл ажиллагаагаа ил тод, нээлттэй явуулдаг. Санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүн нь тухайн хэсгийн санал хураалтын дүн байдаг учраас сонгуулийн үр дүн бүхий мэдээллийг хамгийн түрүүнд хэсгийн хороодод ажиллаж байгаа нам, эвслийн болон нэр дэвшигчдийн томилсон ажиглагчид хүлээн авдаг.

Санал хураалтын дүнг санал тоолох төхөөрөмжийн дүн, Сонгуулийн ерөнхий хорооны төв серверт ирсэн дүн, хяналтын тооллогын дүнг тулган баталгаажуулдаг ба эдгээр 3 эх үүсвэрийн дүн 2012 оноос нэг ч саналаар зөрж байгаагүйг хэсгийн хороодын тайлан, сонгуулийн баримт бичгээс үзэж болно. Мөн саналын хуудасны зурган мэдээлэлтэй ч тулгаж шалгах эрх нь нам, эвслээс болон нэр дэвшигчдээс томилон ажиллуулж байгаа ажиглагчдад бий.

Сонгуулийн албан ёсны дүн, санал тоолох төхөөрөмжөөс гарсан үр дүнгийн тайлантай зөрсөн тухай мэдээлэл, гомдлыг сонгуулийн байгууллагад гарган шалгуулах боломж нээлттэй байдаг. Сонгогч та өөрийн өгсөн саналдаа ямарч эргэлзээгүй, итгэлтэй байж болно.

Сонгуулийн ерөнхий хорооноос санал хураалтын дүнгийн талаар албан ёсны мэдээлэл гаргаагүй байхад аливаа этгээд санал хураалтын дүнгийн талаар мэдэгдэл хийхийг хориглоно.



- Хэсгийн хороод тухайн хэсгийн дүнг гаргана.
- Улсын хэмжээнд **байгуулагдсан нийт хэсгийн хорооноос** санал хураалтын дүнг Сонгуулийн ерөнхий хорооны төв сервер лүү нэн даруй дамжуулдаг.
- Ээлжит сонгуулийн дүнг иргэдэд шуурхай танилцуулах зорилгоор дэлгэцээр шууд харуулдаг.
- Өмнөх сонгуулиудад хяналтын тооллогыг 50 хүртэлх хувьд хийдэг байсан. Харин 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуульд хяналтын тооллогыг бүх хэсгийн хороонд 100 хувь хийж, саналын хуудсыг гар аргаар дахин нягтлан тооллоо.
- Сонгуулийн хороодоос ирүүлсэн цаасан баримтуудыг тулган шалгаж, дүн баримтыг нэгтгэдэг.
Бүх хэсгийн хороонд сонгуулийн үеийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор хяналтын камер суурилуулж, нийслэлийн болон аймгийн төвийн хэсгүүдийн камерыг нэгдсэн сүлжээнд холболоо.



СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРОО

Хаяг: Монгол Улс Улаанбаатар - 38,
Ж.Самбуугийн гудамж - 11, Засгийн газрын 11 дүгээр байр,
Сонгуулийн ерөнхий хороо

Утас: (976) - 51-263602

Факс: (976) -11- 326975

И-мэйл: gesm@ges.gov.mn

Фэйсбүүк: Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороо